



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг
хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн
төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан
тодорхойлох тандан судалгаа**

2024

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur.)

Судалгааны багийн бусад гишүүд:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын эрхлэгч (LL.M)

Х.Буянбат

Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

С.Нарантунгалаг

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ахлах ажилтан

Э.Анударь

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ахлах ажилтан

Б.Баярмаа

Нийтийн эрх зүйн секторын
Эрдэм шинжилгээний ажилтан

Э.Тамир

Олон улсын эрх зүй, хүний эрхийн секторын
Эрдэм шинжилгээний ажилтан

**Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай
анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тодорхойлох тандан
судалгаа**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	Error! Bookmark not defined.
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	3
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	5
1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох.....	12
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох.....	18
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл.....	18
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	21
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАНУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	22
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	24
4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	24
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	Error! Bookmark not defined.
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	Error! Bookmark not defined.
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Error! Bookmark not defined.
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.....	40
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	59
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	61
ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	61
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	68

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НАТХБХХАНТтХ	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хууль
ХБХХАНТНАТтХ	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЭЗИТБДтХ	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ын Зорилго 5-д “...хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.”¹ гээд Зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” хэмээн зааж Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат буюу 2021-2030 оны хугацааг “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе” гэж тодорхойлжээ. Мөн **Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан** “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны зорилт 5.6-д “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” гээд тус зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.”² хэмээн заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)”-ийн зорилт 4.3-т “Авлигын улмаас олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, мөнгө угаах эрсдэлийг бууруулж, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.” гээд тус зорилтын 4.3.1-т “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг тогтмол шинэчилж, олон нийтэд нээлттэй болгоно. Мэдээлэл ирүүлээгүй хуулийн этгээдийн хүлээх үүрэг, хариуцлагыг чангатгана.” гэж, Зорилт 6.1-ийн 6.1.4-т “Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”, Зорилт 6.2-т “Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх үндэслэл болгон хэрэглэх, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах ажлыг эрчимжүүлж, дотоодын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.”, Зорилт 6.3-т “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бүрдүүлнэ.”, Зорилт 6.4-ийн 6.4.1-т “Орлогоосоо давсан зарлагатай, хөрөнгө, орлогын эх үүсвэрээ нотолж чадаагүй албан тушаалтныг нийтийн албанаас чөлөөлөх, эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”³ гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-ийн 4.2.1.1-т “Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.”, 4.2.1.2-т “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.”⁴ гэж тус тус заажээ.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211058&showType=1>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760139806351&showType=1>

⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>

Дээр дурдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого тэргүүтэй бодлогын баримт бичгүүдэд авлигагүй нийгмийг цогцлоон бүрдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бий болгох тухай нийтлэг байдлаар заасан байна. Үүнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/41 тоот тушаалаар Авлигын эсрэг багц хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулан ажиллаж байна.

Энэхүү судалгаагаар нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагатай эсэхийг 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

Судалгааны аргачлал

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв.

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлуудыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын⁵ 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын Их Хурал 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг баталж, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих орон тооны бус Үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулсан.^[1] Улмаар 2005 онд манай улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нэгдэн орж, улмаар 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага болох Авлигатай тэмцэх газар байгуулагдан 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

2023 онд Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн дүнгээр Монгол Улс 33 оноо авч, 180 улс орноос 121 дүгээр байрт эрэмбэлэгдсэн. Уг индексээр Монгол Улс 2012-2023 онд дунджаар 36.17 оноо авсан. Сүүлийн 12 жилийн хугацаанд АТИ-ийн дэлхийн дундаж оноо өөрчлөгдөөгүй буюу 43 оноо байна (боломжит 100 онооноос). Дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь 50-аас доош оноо авсан нь эдгээр улс орнуудад авлига ноцтой асуудал болсныг илтгэж байна. Мөн шүүхийн тогтолцоо суларч буй дэлхий нийтийн чиг хандлага нь нийтийн албан тушаалтны хариуцлагыг бууруулж, улмаар авлига цэцэглэх боломжийг олгож байгааг Транспэрэнси Интернэшнл байгууллага онцлон тэмдэглэжээ.

Сүүлийн 4 жилд авлигын индекс оноо өгдөг судалгааны байгууллагууд Монгол Улсад дор дурдсан оноог өгсөн байна.

Хүснэгт 1. Монгол Улсын авлигын индекс өгсөн үнэлгээ^[2]

№	Байгууллага-судалгаа	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Пи Ар Эс групп – Эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	41	37	32	33
2	Ай Эм Ди – Дэлхийн өрсөлдөх чадварын эмхэтгэл, Үзэл бодлын судалгаа 2020, 2021	32	29	30	33
3	Ардчиллын олон талт байдлын төсөл 2020, 2021	34	34	28	25
4	Дэлхийн эдийн засгийн форум – Үзэл бодлын судалгаа	28	34	30	-
5	Бертелсман сан – Шилжилтийн индекс 2020, 2022	37	37	37	37
6	Дэлхийн банк – Улс орны бодлого, институцийн үнэлгээ 2019, 2020	35	-	-	-
7	Эдийн засгийн мэдээллийн нэгж – Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ 2020, 2021	33	33	37	37
8	Дэлхийн эрх зүйн төсөл – Хууль дээдлэх ёсны индекс	33	35	35	33
9	Глобал инсайт байгууллага – Улс орнуудын эрсдэлийн түвшин 2019, 2020	35	35	35	35
Дундаж оноо		35	35	33	33

Ийнхүү Монгол Улс авлигын төсөөллийн индексийн дундаж оноогоор:

- 2020 онд 35 оноо авч 180 орноос 111 дүгээр байр;
- 2021 онд 35 оноо авч 180 орноос 110 дугаар байр;
- 2022 онд 33 оноо авч 180 орноос 116 дугаар байр;
- 2023 онд 33 оноо авч 180 улсаас 121 дүгээр байрт тус тус эрэмбэлэгджээ.

Дээрх тоон мэдээнээс харвал, 2022-2023 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад авлигын төсөөллийн индексийн оноо 2-оор буурч, 6-11 байр ухарсан үзүүлэлттэй байна. Авлигын индекс буурч, хэлбэлзэж байгаа нь ардчилсан тогтолцоо бэхжээгүй, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг улс төрийн намуудын төлөвшил муу байгааг шууд харуулж байна хэмээн үнэлжээ. Тус судалгаанд Ази номхон далайн бүс нутгаас хамрагдсан 31 орны дундаж оноо нь 45 байгаатай харьцуулвал Монгол Улс бүс нутгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Энэхүү судалгаанд хамрагдсан 180 орноос дундаас доогуур орлоготой 50 улсын авлигын төсөөллийн индексийн дундаж оноо нь 33 байна. Харин манай улсын хувьд сүүлийн 2 жил 33 оноо нь авсан нь энэ ангилалд багтах үндэслэл болжээ.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын засгийн газар Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2.7-д "...хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх..." гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан "...нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах..." гэж тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын "Засаглал"-ын зорилт, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Төрийн бүтээмжийн сэргэлт"-ийн зорилтыг тус тус үндэслэн Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг баталсан бөгөөд тус хөтөлбөрийн зорилго 6-д "Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэж, 6.1.4-т "Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ" гэж, 6.1.5-д "Авлигын гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлох, хахууль авах, өгөх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, дураараа аашлах зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлж тодорхойлно" гэж тус тус заажээ.

Авлигын гэмт хэрэгт ЭХХШтХ-ийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Авлигатай тэмцэх байгууллага хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байна.

Авлигатай тэмцэх газрын сүүлийн дөрвөн жилийн тайлангаас үзвэл:

Хүснэгт 2. Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт^[3]

№	Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	487	594	684	870
2	Харьяаллын дагуу шилжүүлсэн	27	44	52	44

3	Эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	462	460	621	701
4	Ажиллагаанд	44	46	56	55
Нийт шалгасан гомдол, мэдээлэл		1020	1144	1413	1670

Хүснэгт 3. Шалгасан хэрэг

Он	Хэргийн тоо	Өссөн, буурсан хувь	Холбогдогчийн тоо	Өссөн, буурсан
2020	1331	-	696	-
2021	1307	-1.8%	909	+30.6%
2022	1520	+16.2%	1184	+30.2%
2023	1837	+21.0%	1402	+18.4%

Дээрх 2 хүснэгтээс харвал, авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргийн тоо жил ирэх тусам өсөж байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг зүйл, ангиар задлан үзвэл:

Хүснэгт 4. Шалгасан хэрэг /төрлөөр/^[4]

№	Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг	Он			
		2020	2021	2022	2023 ^[5]
1	22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	799	820	1011	1011
2	22.3 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах	-	-	-	-
3	22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах	-	-	-	-
4	22.5 дугаар зүйл. Хахууль өгөх	108	134	138	138
5	22.6 дугаар зүйл. Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах	-	-	-	-
6	22.7 дугаар зүйл. Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх	1	-	-	-
7	22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	23	20	22	22
8	22.9 дүгээр зүйл. Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	-	-	-	-
9	22.10 дугаар зүйл. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	41	36	52	52
10	22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах	3	-	-	-
11	22.12 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	21	26	34	-
12	22.13 дугаар зүйл. Хахууль авах	207	225	239	239

13	Бусад	50	225	258	258
Нийт		1331	1543	1806	1806

Дээрх хүснэгтээс үзвэл, Авлигын гэмт хэргүүдээс Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэг хамгийн их үйлдэгдсэн байна.

Хүснэгт 5. Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Он	Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	Өмнөх онтой харьцуулахад өссөн, буурсан хувь
2020	114	-
2021	160	+40.3%
2022	188	+17.5%
2023	192	+2.1%

Дээрхээс хүснэгтээс үзвэл, Авлигатай тэмцэх газраас тухайн жилд мөрдөн шалгасан нийт хэргийн 10 орчим хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж байна.

2022 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Энэ хуульд заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй. Авлигын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй...” гэж нэмэлт оруулсан. Мөн тус хуулийн 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй...” гэж заасан нь төрөөс авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулсан ялыг бүрэн бодитой эдлүүлэхэд чиглэсэн бодлого баримталж байгааг харуулж байна.

Монгол Улсын хувьд авлигын гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх асуудлыг Эрүүгийн хуульд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээгээр зохицуулж байна.

2002 оны Эрүүгийн хуульд хөрөнгө орлогыг хураах нь эрүүгийн ялын төрөлд хамаарч ирсэн бөгөөд тус хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана” гэж заасан байжээ.

Харин 2015 оны Эрүүгийн хуулиар хөрөнгө хураах ялыг тус хуулийн 7.2 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээний нэгэн төрөлд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ болгон хуульчилсан байна. Энэ нь дэлхийн өндөр хөгжилтэй улсуудын туршлагыг харгалзан хийсэн өөрчлөлт юм. Ингэснээр гэмт этгээдэд ял завшуулах, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, орлогоо завших боломж олгохгүй ач холбогдолтой.

Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд шүүх энэхүү арга хэмжээг хэрэглэхдээ хураах эд зүйл, түүний үнэ, эд хөрөнгө, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд оногдох эд хөрөнгө гэдгийг иргэний эрх зүйн агуулгаар ойлгоно. Монгол Улсын Иргэний хуулийн 127 дугаар зүйл. Гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө /хувьд оногдох/ өөрийн үзэмжээр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй бөгөөд өөрөөр тохиролцоогүй бол гэр бүлийн гишүүд хувийн үйл ажиллагаатай холбогдсон үүргээ өөрийн хуваарьт эд хөрөнгөөр хариуцдаг.^[6]

Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно...” гэж заажээ.

Мөн энэ хуульд хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлага болгож хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт хуульчилсан байна. Улмаар тус хуулийн 9.5, 9.6 дугаар зүйлд үүнийг тухайлан зохицуулсан байна.

Эрүүгийн хуулийн 9.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Хуулийн этгээдийг татан буулгасан тохиолдолд хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ...” гэж, 9.6 дугаар зүйлийн 1-д “...Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна...” гэж, тус зүйлийн 2 дахь хэсэгт “...Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ энэ хуулийн 7.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална...” гэж тус тус заажээ.

Өөрөөр хэлбэл, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хүнд хамаараад зогсохгүй хуулийн этгээдэд оногдуулж болох эрүүгийн хариуцлагын төрөл юм.

Шүүхийн шийтгэх тогтоолд заасан эд хөрөнгийг бүрэн хурааж, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлснээр уг арга хэмжээг биелүүлсэнд тооцно.

Монгол Улсын хувьд 2019-2023 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг гүйцэтгэсэн байдлыг харвал:

Хүснэгт 6. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан

Он	Гүйцэтгэвэл зохих этгээдийн тоо	Гүйцэтгэсэн этгээдийн тоо	Үлдэгдэл
----	---------------------------------	---------------------------	----------

2019	523	400	123
2020	961	641	320
2021	1316	808	508
2022	1640	1161	479
2023	1951	1067	884

Дээрх хүснэгтээс харвал, жил ирэх тусам хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан тохиолдол нэмэгдэж байна.

Сүүлийн 3 жилд зөвхөн АТГ-ын хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд албан тушаалтны хөрөнгөжих, нуугдмал хөрөнгийг олж илрүүлсний үндсэн дээр битүүмжлэх болон хураан авсан эд хөрөнгийн нарийвчлан үзье.

2022 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 5.024.895.829.317,00 (таван их наяд, хорин дөрвөн тэрбум, найман зуун ерэн таван сая, найман зуун хорин есөн мянга, гурван зуун арван долоо) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 2.374.934.309.243,00 (хоёр их наяд гурван зуун далан дөрвөн тэрбум, есөн зуун гучин дөрвөн сая, гурван зуун есөн мянга, хоёр зуун дөчин гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 518.039.332.298,00 (таван зуун арван найман тэрбум, гучин есөн сая, гурван зуун гучин хоёр мянга, хоёр зуун ерэн найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 5 дахин, **нөхөн төлүүлэлт 24.7 дахин**, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна. **Нийт учирсан хохирлын 47.3 хувийг нөхөн төлүүлж**, хахуулийн 18,874,521.566 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө **хураан авсан**.

2023 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 845.797.805.525,00 (найман зуун дөчин таван тэрбум, долоон зуун ерэн долоон сая, найман зуун таван мянга таван зуун хорин тав) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 238.689.979.559,00 (хоёр зуун гучин найман тэрбум, зургаан зуун наян есөн сая, есөн зуун далан есөн мянга таван зуун тавин ес) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 17.137.615.448,00 (арван долоон тэрбум, нэг зуун гучин долоон сая, зургаан зуун арван таван мянга, дөрвөн зуун дөчин найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. **Нийт учирсан хохирлын 28.2 хувийг** мөрдөн шалгах ажиллагааны явцад **нөхөн төлүүлж**, хахуулийн 8.680.730.871 (найман тэрбум зургаан зуун наян сая долоон зуун гучин мянга найман зуун далан нэг) төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

2024 оны эхний хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас 428.213.259.053,06 (дөрвөн зуун хорин найман тэрбум хоёр зуун арван гурван сая хоёр зуун тавин есөн мянга тавин гурав) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 213.721 956.513,75 (хоёр зуун арван гурван тэрбум долоон зуун хорин нэгэн сая есөн зуун тавин зургаан мянга таван зуун арван гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 20.756.341.909,00 (хорин тэрбум долоон зуун тавин зургаан

сая гурван зуун дөчин нэгэн мянга есөн зуун ес) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Дээрхээс дүгнэвэл, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх хэрэгцээ, шаардлага зайлшгүй үүссэн байна хэмээн үзэх нь үндэслэлтэй байна.

Иймд аргачлалын дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тухайн асуудлын хүрээнд түүний мөн чанар, цар хүрээ, шалтгаан, нөхцөлийг тогтоож эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийн эрхэд тухайн асуудал хэрхэн нөлөөлж буй талаар авч үзсэн болно.

1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

“Хөрөнгө хураан авах” гэдэг нь шүүх болон эрх бүхий бусад байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авахыг хэлнэ. Хөрөнгийн эрх, гэрчилгээг улс өөрийн нэр дээр шилжүүлэн авах бөгөөд тэдгээрийг эзэмшиж байсан этгээдэд ямар нэгэн нөхөн төлбөр олгохгүй. Хөрөнгийг хураан авахад хууль сахиулах байгууллагын албан хаагчид, прокурор, шүүгч, санхүүгийн шинжээч, хөрөнгийн менежер эсвэл хөрөнгийн удирдлагын агентлаг зэрэг төрөл бүрийн ур чадвартай хувь хүн, байгууллагууд харилцан уялдаа холбоотой, хамтран ажиллах шаардлагатай.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц ба ФАТФ-ын Зөвлөмжүүд (ФАТФ 2019) шийтгэх тогтоолгүйгээр хөрөнгө хураахыг дэмждэг бөгөөд хөрөнгө хураан авах талаар зохицуулалтыг өргөжүүлж, уг зарчмыг хүлээн зөвшөөрөн шинээр нэвтрүүлж буй улс орны тоо өсөн нэмэгдсээр байна. Хөрөнгө хураан авах үндэслэл нь:

Нэгдүгээрт, хууль бус орлого бий болгож буй авлига, бусад гэмт хэрэг нь төр, Засгийн газар, эсвэл хувь этгээдэд хохирол учруулдаг тул тэдгээрт нөхөн төлбөр олгогдох ёстой.

Хоёрдугаарт, эдгээр гэмт хэргийг үйлдэх үндсэн зорилго нь хууль бус орлого олох явдал байдаг тул хөрөнгийг хурааснаар ашиг шимийг нь хүртэх боломжгүй болгож улмаар урьдчилан сэргийлэх үр нөлөө үзүүлдэг. Тухайлбал, хөрөнгө хураан авах нь “гэмт хэрэг үйлдэж орлого олох боломжгүй” гэсэн ойлголтыг бий болгох зорилготой.

Хөрөнгө хураахтай холбоотой хууль тогтоомж, практикт ажиглагдаж буй томоохон ач холбогдол бүхий чиг хандлагын нэг нь няцаагдах боломжтой презумпци буюу үндэслэл бүхий таамаг, дүгнэлтийг илүү өргөнөөр ашиглах болсон явдал юм. Презумпци гэдэг нь бодит баталгаагүй нөхцөлд учир шалтгааныг магадлах, тунгаан бодох замаар тодорхой нөхцөл байдалд тулгуурлан баримт, таамаглалын үнэн болохыг тогтоосон гаргалгаа, дүгнэлтийг хэлнэ.

Төрийн албан хаагчдын авлигын хэргүүдэд гэмт үйлдэл болон шүүгдэгчийн өмчилж, эзэмшиж буй хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох бараг боломжгүй байдаг. Энэ тохиолдолд презумпци чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэх хугацаанд олсон орлого, хөрөнгийнхөө гарал үүслийг өөрөө тайлбарлаж чадахгүй нөхцөлд прокурорын байгууллагаас уг хөрөнгийн эх үүсвэр хууль бус болохыг нотлох шаардлагагүй болсон нь яллах ба хөрөнгө хураах шийдвэр гарах магадлалыг ихээхэн нэмэгдүүлж өгсөн. Мөн хөрөнгийн үнэлгээнд суурилсан хөрөнгө хураах хэлбэр буюу гэмт хэргийн улмаас олсон ашиг хонжооны дүнг шүүх болон эрх бүхий байгууллагууд тооцоолж тухайн дүнд дүйцэх хөрөнгийг шүүгдэгчээс хураах шийдвэр гаргадаг.

Хөрөнгө хураах тухай хууль тогтоомжийн түүхэн хөгжил ба сүүлийн үеийн чиг хандлага

Хөрөнгө хураах концепци нь олон жил хэрэгжиж байгаа бөгөөд олон мянган жилийн өмнөх хуулийн баримт бичгүүдэд хөрөнгө хураах жишээнүүдийг дурдсан байдаг. Эдгээр эртний хуулиудаас өвлөгдөн ирсэн хөрөнгө хураах хуулиуд Английн хуулийн тогтолцоо, Эх газрын эрх зүйн тогтолцооны аль алинд нь шингэн тусгагдсан. 1980-аад онд мансууруулах бодисын наймаа,

зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлт нэмэгдэхийн хэрээр зарим улс оронд эрүүгийн журмаар хөрөнгө битүүмжлэх, мөн яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

Сүүлийн жилүүдэд хууль бус хөрөнгө, орлогыг хураах нь илт ихэссэн ч гэмт хэрэг үйлдэж олсон орлого маш өндөр байхад хураасан хөрөнгийн хэмжээ их биш байгаа юм. Үүнтэй холбоотойгоор хөрөнгө, орлогыг хураах хууль тогтоомжид шинээр дараах чиг хандлага бий болсон. Үүнд:

- Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах заалтыг нэвтрүүлсэн;
- Хөрөнгө хураах үнэлгээнд суурилсан аргачлалыг хөгжүүлсэн;
- Нотлох баримтын стандартыг бууруулсан;
- Зарим нөхцөлд нотлох шаардлагаас чөлөөлсөн;
- Презумпцийг илүү өргөнөөр ашиглах болсон;
- Гэмт хэргийн бэлэн мөнгө, бусад хэрэгслийг шүүхийн бус буюу захиргааны аргаар хураах тохиолдол нэмэгдсэн.

Хууль бус хөрөнгийг хураан авах журам

Авлигын хөрөнгө орлогыг хураах гурван төрөл байна. Үүнд:

- эрүүгийн журмаар,
- яллах шийдвэргүйгээр,
- захиргааны журмаар.

Мөн зарим оронд холимог тогтолцоог хэрэглэж байна. Тухайлбал, шүүхэд нэхэмжлэл гаргах, тусгаарлах зэрэг иргэний процессийн арга хэмжээг хэрэглэж хөрөнгө, орлогыг хураадаг.

Эрүүгийн журмаар хөрөнгө хураах

Эрүүгийн журмаар яллаж хөрөнгө хураахын тулд шүүхээр хэлэлцэж яллах шийдвэр гаргуулсан эсхүл шүүгдэгч гэм буруугаа хүлээж зөвшөөрсөн байх ёстой байдаг. Яллах дүгнэлт гарсан хойно шүүхээс хөрөнгө хураах эцсийн шийдвэр гаргадаг, ихэнх тохиолдолд энэ нь шүүгдэгчид оногдуулсан ялын нэг хэсэг байдаг. Зарим улс орнуудад хөрөнгө хураах нь шүүхийн шийдвэрт заавал ордог бол зарим улсад шүүх эсхүл тангарагтны шүүх уг асуудлыг өөрийн үзэмжээр шийддэг. Эрүүгийн журмаар хөрөнгө хураах нь өмчид суурилсан, үнэлгээнд суурилсан, эсвэл хослуулсан байж болдог.

Зарим улс оронд (тухайлбал, яллах үйл явц, хөрөнгө хураах үйл явц гэх мэт) хэргийн хоёр үе шатанд эд мөрийн баримтын тухайд өөр өөр стандартууд ашиглаж болдог. Яллах ажиллагааны тухайд эрүүгийн стандартын дагуу тавигддаг нотолгоо, эд мөрийн баримтыг бүрдүүлж шүүгдэгчид яллах дүгнэлт гаргуулах нь прокурорын хувьд хамгийн чухал асуудал байдаг, үүнд нийтийн эрх зүйн тогтолцоотой улс оронд “үндэслэл бүхий сэжиг”, харин эх газрын эрх зүйн тогтолцоонд “бодит үнэнийг тогтоох” зарчмыг ашиглаж болно. Гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг нотлохын тулд эд мөрийн баримт, нотолгооны энэ стандартыг эхний ээлжид хангасан байх ёстой, үүний дараа хөрөнгө хураах асуудал яригдана.

Хөрөнгө хураах ажиллагааны тухайд эд мөрийн баримт, нотолгооны өөр стандарт мөрдөгдөж болох хэдий ч хөрөнгө хураах асуудлыг хэлэлцэх явцад үйлдсэн хэрэг, хураах хөрөнгө хоорондын хэлхээ холбоог тогтоох зэрэг нэмэлт шаардлагыг шүүхээс тавьж болно. Зарим улсад ийм хоёрдогч шаардлагыг хангахад нотлох баримтын стандартын “магадлалын тэнцвэр” доогуур байхыг зөвшөөрдөг бол заримд нь эрүүгийн яллах ажиллагаа, хөрөнгө хураах ажиллагаанд яг ижил түвшний нотлох баримт шаарддаг.

Яллах шийдвэр гарсан байх шаардлага үйлчилж байгаа нөхцөлд хэрэгтэн нас барсан, өөр орон руу зугтсан, эсхүл өөр ямар нэг шалтгаанаар шүүхээр орох боломжгүй болсон тохиолдлуудад хөрөнгө хураахад бэрхшээлтэй болдог. Хэрэгтэн оргон зайлсан гэдэг нь тогтоогдсон бол зарим улсад холбогдогчийн эзгүйд шүүх хурлыг явуулдаг, эсвэл хөрөнгө хураах зорилгоор хэрэгтэнг “ялагдсанд” тооцдог болсон.

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах

Яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах (зарим тохиолдолд “иргэний журмаар” хөрөнгө хураах гэгддэг) нь ихэнх тохиолдолд хөрөнгийг эзэмшиж, өмчилж буй этгээдийн эсрэг бус өмчид суурилсан тухайн хөрөнгийн эсрэг ажиллагаа байдаг тул яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах ажиллагаанд тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан гэдгийг нотлоход л хангалттай байдаг. Үүнд холбогдогч этгээдийн эсрэг яллах шийдвэр гарсан эсэх нь хамаагүй. Ийм төрлийн хөрөнгө хураалт хоёр арга замаар явагддаг.

Нэгд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд явагддаг, гэхдээ яллах шийдвэр гарах, гэм буруутайг нотолсон байх шаардлага тавигддаггүй. Энэ тохиолдолд яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах хуулийг Эрүүгийн хууль, Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль, эсхүл өөр бусад эрүүгийн хууль тогтоомжид нэгтгэн оруулдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг гэж үздэг.

Хоёрт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас тусдаа, бие даасан байдлаар эсвэл зэрэгцээ ажиллагаа явуулах боломжтой бие даасан хууль гаргаж хөрөнгө хураах нь яллах шийдвэргүйгээр хөрөнгө хураах. Энэ нь эрүүгийн гэхээсээ илүүтэйгээр иргэний эсхүл захиргааны журмаар явагдах нь түгээмэл байдаг. Иргэний журмаар хөрөнгө хураах зарчим ашигладаг улс орнуудад нотлох баримтын стандартын “магадлалын тэнцвэр” эсхүл “нотлох баримтын давамгайл байдал” доогуур байхыг зөвшөөрдөг тул өмч, хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан гэдгийг прокурор нотлох үүрэг, шаардлагыг бууруулж өгдөг. Гэхдээ гэмт хэрэг үйлдэгдсэн, тухайн хөрөнгийг гэмт хэргийн улмаас олж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан гэдгийг нотлох шаардлага тавигдсан хэвээр байдаг. Нотлох баримт нь эрүүгийн журмаар яллах дүгнэлт гаргахад хангалтгүй нөхцөлд хөрөнгө хураах шийдвэр гаргаж болдог.

Захиргааны журмаар хөрөнгө хураах

Захиргааны журмаар хөрөнгө хураахад шүүхийн шийдвэр шаардлагагүй байж болдог. Гэхдээ улс орноос хамааран зарим тохиолдолд шүүхээр орох шаардлагатай байдаг. Аль нэг тал хөрөнгө хураахыг эсэргүүцээгүй, мөн тодорхой (жишээлбэл, талуудад мэдэгдэл хүргүүлсэн, хэвлэн нийтэлсэн, мөн сөрөг нэхэмжлэл ирээгүй гэх мэт) шаардлагууд хангагдсан нөхцөлд түгээмэл ашигладаг. Үүнээс гадна, захиргааны журмаар хураах хөрөнгийн үнийн дүнд дээд

хэмжээ заах, эсхүл төрөл зүйлийн жагсаалт гаргах гэх мэтээр үйлчлэх цар хүрээг хязгаарлах заалтуудыг хуульд тусгадаг. Мөн захиргааны журмаар хөрөнгө хураах тухай хуулиудад зарим шийдвэрийг шүүхээс гаргах тухай зохицуулалт оруулах тохиолдол түгээмэл байдаг.

Хураан авах үйл ажиллагаа

Хөрөнгө хураахад 1/ хөрөнгөд суурилсан (тодорхой хөрөнгийг зааж өгдөг), эсхүл 2/ үнэлгээнд суурилсан (тодорхой этгээдийн төлөх ёстой үнийн дүнг зааж өгдөг) гэх хоёр аргачлалыг ашигладаг. Зарим улс оронд энэ хоёр аргачлалыг аль алийг нь хослуулан ашигладаг бөгөөд олж тогтоосон хөрөнгө, орлогыг хураах, мөн холбогдогч этгээдийн хууль ёсны өмч хөрөнгөөс хохирлыг барагдуулах шийдвэр гаргуулдаг. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд нийтлэг зүйл олон байдаг. Гэхдээ ашиглаж буй журам, үйл явц, хөрөнгө, орлогыг хураахад тавигддаг нотлох баримт, эд мөрийн баримтын шаардлага, стандартууд нь ялгаатай.

Авлигын замаар олсон орлогыг хураах нь дараах зорилготой.

1. Урьдчилан сэргийлэх: Авлига авсан албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах нь шинээр гэмт хэрэг үйлдэхээс сэргийлээд зогсохгүй ижил төрлийн гэмт хэрэгт өртөмтгий бусад хүмүүст сэрэмжлүүлэг болдог.
2. Хохирол нөхөн төлүүлэх/нөхөн сэргээх: авлигын гэмт хэргийн хохирогчдын хохирлыг нөхөн төлүүлэх, төр, нийтийн болон бусдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах зэрэг үндсэн агуулгуудад багтана.

Зарим улс оронд авлигын гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл, олсон орлогыг хураахаас гадна ял шийтгүүлсэн хүний бүх хөрөнгийг, тэр дундаа хууль ёсны дагуу, хууль ёсны эх сурвалжаас олж авсан эд хөрөнгийг ч хураан авдаг.

Хөрөнгө хураах нь шийтгэлийн үүрэг гүйцэтгэдэг CAN (Зүүн Европ ба Төв Азийн авлигын эсрэг сүлжээ)-ийн орнууд.

- Армeни, Беларусь, Казахстан, Киргизстан, Тажикистан, Туркменистан, Украин зэрэг багтана.

Урьдчилсан сэргийлэх үүрэг гүйцэтгэдэг бүс нутгийн орнууд.

- Азарбайжан, Гүрж, Литва, Молдав, Румын, Сeрби, Словени, Хорват, Монтенегро, Эстони зэрэг.

Ихэнхи улс оронд эд хөрөнгө хураах нь хохирогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, эсвэл хураагдсан эд хөрөнгийн зардлаар тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нөхөн сэргээх чиг үүрэгтэй байдаг.

Хөрөнгө хураах журмын 3 үе шат:

1. Мөрдөн шалгалтын үе. Энэ үе шатанд гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх, байршлыг тогтоох, эзэмшигчийн талаарх нотлох баримт (мөн эд хөрөнгийн талаарх мэдээлэл)-ыг цуглуулах санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг хийнэ. Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд шүүхийн шийдвэрээр хожим хураан авах зорилгоор түр зуурын арга хэмжээ (битүүмжлэх) авч болно.

2. Шүүхийн үе шат. Энэ үе шатанд ял шийтгэл оногдуулах (эсвэл, цагаатгах), эсвэл эд хөрөнгийг хураах талаарх эцсийн шийдвэрийг шүүхээс гаргана.
3. Удирдах үе шат. Төрөөс тухайн эд хөрөнгийг бодитоор хураан авч олон улсад хөрөнгө хуваарилах, хууль тогтоомжын дагуу захиран зарцуулах үе шат.

Манай улсын хувьд хөрөнгө, орлогыг хураах эрх зүйн зохицуулалтыг ерөнхийд нь:

1. Эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа
2. Иргэний журмаар хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа
3. Захиргааны журмаар хөрөнгө, орлогыг хураах ажиллагаа гэж хувааж байна.

Үүнээс эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлого хураах ажиллагаа нь *in personam* буюу шүүгдэгчийн эсрэг биечлэн хийх үйлдэл байдаг ба яллах дүгнэлтэд эд хөрөнгийг хураах саналтай байгаа тухай тусгадаг. Ингэхдээ ял шийтгэл заавал оногдуулах шаардлагатай ба эд хөрөнгө хураах нь тухайн ялын нэг хэсэг болдог. Эрүүгийн эрх зүйн хөрөнгө, орлого хураах ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн ашиг сонирхлоор хязгаарлагддаг бөгөөд үүнд шүүгдэгчийн хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогыг хамаатуулан ойлгодог. Өөрөөр хэлбэл, яллагдагчийг ялласан тодорхой тооллогод хамаарах эд хөрөнгөөр хязгаарлагддаг.

Түүнчлэн, Монгол Улсын хувьд хөрөнгө орлогыг хураах нь Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор эрүүгийн хуулийн тусгай ангийн санкцид заасан ялаас гадна ялтанд тусгай үүрэг хүлээлгэж эрхийн хязгаарлалт тогтоохыг хэлнэ гэж тодорхойлсон.^[7] Мөн үүнээс гадна албадлагын арга хэмжээг гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдэд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулдаг, ялын бус шинжтэй, төрийн албадлагын арга хэмжээний төрлийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Албадлагын арга хэмжээг Эрүүгийн хууль тогтоомжид ялаас гадна аюулгүй байдлын арга хэмжээг оногдуулж болдог дуалист тогтолцоо бүхий улс орнуудад албадлагын гэхээс илүүтэйгээр тухайн этгээдийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн гэмт этгээдийн өөрийнх нь эрх ашигт нийцсэн арга хэмжээг давхар хэрэглэдэг бөгөөд энэ нь ял биш, гагцхүү гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж буй этгээдэд шүүхээс оногдуулсан ялтай хамтатган хэрэглэдэг жишиг гадаадын улс орнуудад тогтсон байна.

Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг хэлбэр боловч ялаас ялгагдах дараах онцлог шинжтэй^[8]. Үүнд:

- Албадлагын арга хэмжээ нь ял биш /ялын шинжийг агуулдаггүй/, ялын төрөл биш. Эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай болох нь нотлогдсон хүнтэй үр дүнтэй ажиллах, хувь хүнд нөлөөлөх шинжтэй арга хэмжээ юм.
- Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл бөгөөд бие даасан ойлголт, ухагдахуун юм.
- Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын төрөл, хэмжээг тухайн зүйлийн санкцад тогтоосон, шүүх тухайн төрөл, хэмжээний дотор ял оногдуулдаг бол тусгай ангийн санкцид албадлагын арга хэмжээ, түүний төрөл, хэмжээг хуульчилж өгөөгүй. Харин Эрүүгийн хууль дахь тусгай журмаар зохицуулдаг.

Албадлагын арга хэмжээний дээрх тодорхойлолт болон зорилгод хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь мөн хамаарна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ нь эрүүгийн ялын зорилгыг хангах, ялын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулах ялын бус, өөрийн эрх ашигт нийцсэн тусгай үүрэг хүлээлгэж эрхийн хязгаарлалт тогтоох үйл ажиллагаа юм.

ЭХХШТХ-ийн 21 дүгээр бүлэгт “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ”-ний талаар зохицуулсан бөгөөд тус хуулийн 21.1 дүгээр зүйлд “Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах” зохицуулалтыг тусгажээ. Тус зүйлийн 1 дэх хэсэгт “...Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна...” гэж мөн зүйлийн 3 дахь хэсэгт “...Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна...”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “...Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг хаана хадгалахыг шүүх, прокурорын шийдвэрт тусгайлан зааж болно...” гэж тус тус заажээ.

Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 191 дүгээр зүйлд хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх талаар зохицуулсан. Гэвч ЭХХШТХ, ШШГТХ-д битүүмжилсэн хураасан эд хөрөнгийг тусгай зориулалтын байранд хадгалуулна гэж заасан боловч ийм төрлийн хадгалах байртай шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага манай улсад байхгүй байна. Тусгай зориулалтай байр нь онцгой бараа бүтээгдэхүүн эд зүйлсийг хадгалах тоног төхөөрөмж тоноглогдсон байх шаардлагыг дотроо агуулна. Гэвч хууль болон журмаар тэрхүү тусгай зориулалтын байрын стандартыг тогтоогоогүйгээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагууд дотооддоо сул, чөлөөтэй өрөө тасалгаандаа хураан авсан хөрөнгөө хадгалж байна. Хөрөнгийг хадгалах тусгай зориулалтын байрын стандарт байхгүйгээс дээр дурдсан хөрөнгийн шинж чанар алдагдах эрсдэлийг давхар үүсгэж байна.^[9]

Өөрөөр хэлбэл, хуульд зохицуулалт нь тусгагдсан боловч практикт тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжгүй байна. Мөн албадлагын арга хэмжээ авч хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг улсын орлого болгож, улсын төсөвт оруулахтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам байхгүй байна.

Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох...” гэж заажээ. Тус хуулийн 7.1.7-д “...албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх...” гэж, 7.1.8-д “...үндэслэлгүйгээр хөрөнгөжих...” гэж заажээ. Энэ нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгтэй ижил агуулгыг илэрхийлж байна. Нөгөөтээгүүр, Эрүүгийн хуульд заасан дээрх 2 төрлийн гэмт хэргийн шинжийг бүрэн хангаагүй ч /тухайлбал, Үндэслэлгүй хөрөнгөжсөн тохиолдолд хохирлын хэмжээ 100.000.000 төгрөг хүрэхгүй байх/ Авлигын эсрэг хуульд зааснаар хариуцлага хүлээх боломжтой мэт харагдаж байгаа боловч практикт энэхүү зохицуулалтаар хариуцлага хүлээсэн тохиолдол байхгүй байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуульд заасан дээрх гэмт хэрэг үйлдсэн гэж үзвэл шүүх Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийг хэрэглэн шийдвэр гаргаж байна. Нөгөөтэйгүүр, Авлигын эсрэг хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дээрх тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан боловч гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн хангагдаагүй тохиолдолд зөвхөн Авлигын эсрэг хуульд зааснаар хариуцлага хүлээлгэх боломжгүй байна. Энэ нь тухайн хүнийг хариуцлагаас чөлөөлөх, ял завших боломжийг олгож байна. Иймд хууль хоорондын уялдаа холбоог хангах зайлшгүй шаардлагатай байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох⁶

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1.	Нийтийн албан тушаалтан	Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт авлигагүй нийтийн албыг бий болгох тухай заасан нь авлигын гэмт хэрэгтэй хийх тэмцэлд нийтийн албан тушаалтны эрх ашиг зайлшгүй хөндөгдөх болохыг харуулж байна.
2.	Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх эрх бүхий субъектууд	Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, тус гэмт хэргийн улмаас бий болсон хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэлтийн байдлыг сайжруулах тухай асуудал нь тус процессыг хуулийн дагуу хэрэгжүүлэгч этгээдүүд болох авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх эрх бүхий субъектуудийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөх нь зүйн хэрэг.
3.	Хүн ам	Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт авлигагүй нийгэм, нийтийн албыг бий болгох тухай зааснаас Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх явдал нь нийт хүн амыг хамруулсан ойлголт болох нь харагдаж байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг хураах асуудал нь практикт түгээмэл үйлдэгддэг зарим гэмт хэрэгтэй харьцуулахад ээдрээ төвөгтэй, цаг хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөц, хамтын ажиллагаа гэх мэт олон талын асуудлаас шалтгаалж байдаг.

Нөгөөтэйгүүр, авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, шүүхээр шийдвэрлэгдэж буй хэргийн тоо жил бүр нэмэгдэж байна. Тухайлбал, АТГ-д ирсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл 2023 онд өмнөх оны 141, шинээр хүлээн авсан гэмт хэргийн талаарх 2015, нийт 2156 гомдол, мэдээллийг хүлээн авснаас 427 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу

⁶ Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Манай судалгааны хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах оролцогчид болон хүн ам зэргээр эрх ашиг нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон тул дээрх бүгд хамаарна.

харьяалах байгууллагад нь шилжүүлж, гэмт хэргийн талаарх 1670 гомдол, мэдээллийг бүртгэлд оруулан шалгасан байна. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 315 нэгжээр буюу 17.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл /2020-2023 он/

Утга	2020 он	2021 он	2022 он	2023 он
Нийт шалгасан гомдол, мэдээлэл	1032	1596	1841	2015

Мөн 2023 оны гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл төрийн улс төрийн 277, төрийн захиргааны 510, төрийн тусгай 729, төрийн үйлчилгээний 148, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 235, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 116 байна.

Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэрэгт нийтийн албан тушаалтан ихэвчлэн холбогдож байна.

Авлигатай тэмцэх газраас шалгасан эрүүгийн хэргийн статистикийн зүйл ангиар задлан үзвэл:

Хүснэгт 9. Авлигатай тэмцэх байгууллагаас шалгасан эрүүгийн хэргийн статистик

№	Зүйл, заалт	2020 он	2021 он	2022 он	2023 он
1.	22.1 дүгээр зүйл	799	820	1011	1249
2.	22.4 дүгээр зүйл	207	225	239	290
3.	22.5 дугаар зүйл	108	134	138	161
4.	22.8 дугаар зүйл	23	20	22	32
5.	22.10 дугаар зүйл	41	36	52	67
6.	22.12 дугаар зүйл	21	26	34	53
7.	Бусад	336	282	310	331
Нийт		1535	1543	1806	2183

Дээрх хүснэгтээс үзвэл, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргүүдээс 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг хамгийн их шалгагдсан байна.

Харин шүүхээр шийдвэрлэгдсэн авлигын гэмт хэрэг 2022 онд 188 байсан бол 2023 онд 192 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн бөгөөд 2023 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуульд заасан торгох ялаар 8306 хүн, 18 хуулийн этгээдэд 15 тэрбум 132 сая 329 мянга 600 төгрөгийн торгох ял, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж 391 хүнээс 15 тэрбум 817 сая 454 мянга 340 төгрөгийг гаргуулан улсын орлого болгосон байна.

Гэхдээ өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг эргүүлэн авахад нэлээдгүй бэрхшээл тулгардаг байна. Нөгөөтэйгүүр, хөрөнгө эргүүлэн өгөх олон улсын шинжтэй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн ялгаатай байдал, мэргэшсэн техник ур чадвар хангалтгүй байх, эргүүлэн өгөх үйл явцыг удирдан зохион байгуулах улс төрийн хүсэл зориг сул байх, авлигын асуудалд нэрвэгдсэн, улс төр, эдийн засаг, нийгэм нь тогтворгүй байгаа улс

оронд хөрөнгө эргүүлэн өгөхтэй холбоотой зовнил түгшүүр зэрэг техникийн болон улс төрийн янз бүрийн саад бэрхшээл тулгарч байна. Авлига, мөнгө угаах, хөрөнгө буцаан олгох ажиллагаанд хоёр өөр улсын шүүх өндөр түвшний авлигын гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг хураан авах, эргүүлэн өгөх асуудалд өөр өөр өнцгөөс ханддаг нь ихээхэн бэрхшээл учруулж байгааг улс орнууд анхааралдаа авч энэхүү сорил бэрхшээлийг арилгахад хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагатай байна.^[10]

Хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх асуудал нь манай улсын хувьд Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан “Хөрөнгө, орлогыг хураан авах, шилжүүлэх” албадлагын арга хэмжээ, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тус хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу “Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ”-ний эрх зүйн зохицуулалттай тус тус холбогдож байна.

Эрх зүйн орчны хувьд хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх боломжийг тодорхойлох үүднээс гадаад орны сайн туршлагыг судлан үзэж хувилбар дэвшүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Шийдвэрлэх зорилгын тухайд өмнөх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрлэх зорилгыг тодорхойлж байна.

Зорилго: “Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэлтийн байдлыг сайжруулах замаар авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх”

Аргачлалын 4.1-д бичсэнээр зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байдлаар томьёолох хэрэгтэй юм. Бидний тодорхойлсон зорилгын тухайд авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэлтийн байдлыг сайжруулах замаар авлигын гэмт хэрэгтэй хийх тэмцлийг илүү үр дүнтэй болгох нь тооцоолох боломжтой байх бөгөөд тус зорилгыг тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байгааг харуулж байна. Мөн тус зорилго нь аргачлалын 4.2-т зааснаар ерөнхий зорилгод хамаарна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэлтийн байдлыг сайжруулах замаар авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх” зорилгоос гадна хангаж чадах бусад хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Авлигын гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд өөрчлөлт гарахгүй. Өдгөө тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжлэнэ.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд одоогийн зохицуулалтын үр өгөөж хэвээрээ байна.	Үр дүн муутай
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх нь хязгаарлагдмал бөгөөд мэдээлэл хомс байна.	Зардал тодорхой хэмжээгээр шаардагдах хэдий ч тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжгүй байдалд хүрнэ.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3.	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийснээр үр нөлөө үзүүлэхгүй.	Төрөөс их хэмжээний зардал гарах хэдий ч үр өгөөжгүй байна.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал нь авлигын гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Асуудал нь авлигын гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6.	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах буюу захиргааны хэм хэмжээний акт буюу журам, дүрмээр	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	

		авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх тухай зохицуулах боломжгүй юм.		Тодорхой үр дүнд хүрэхгүй.
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Асуудлыг шийдвэрлэх боломжтой бөгөөд ийнхүү эрх зүйн орчинг боловсронгуй болгохдоо өнөөгийн эрх зүйн зохицуулалт хоорондын уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг сайжруулах байдлаар шийдвэрлэх нь оновчтой байна.	Төрөөс хууль батлагдах болон үйл ажиллагаатай холбоотой зардал тодорхой хэмжээгээр гарах хэдий ч тус хувилбар нь зорилгод хүрэхэд илүү тохиромжтой, үр өгөөжтэй байна.	Үр дүнтэй.

Дээрхээс “Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэлтийн байдлыг сайжруулах замаар авлигын гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх” зорилгыг хангах хүрээнд дараах хувилбаруудыг дэвшүүлж байна.

Хувилбар 1. *Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх тухай шинэ зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх*

Хувилбар 2. *Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх*

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх

Төрөөс гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хамгаалахад чиглэдэг учир асуудлыг зохицуулахаар сонгож буй хувилбар нь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчсөн, хууль бусаар хязгаарласан байх ёсгүй ба тухайн хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө аливаа хэлбэрээр зөрчигдөх ёсгүй. Иймд үүнийг урьдчилан шалгасан байх шаардлагатай тул энэ хэсэгт шалгах болно.

Доорх хүснэгтэд зохицуулалтын хувилбаруудын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд хариултын тайлбарыг дэлгэрэнгүй байдлаар тусад нь бичсэн болно.

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Эрсдэлтэй.
		Хувилбар 1	Үгүй	Нэг бүлэгт давуу байдал үүсгэхээс сэргийлэхэд ач холбогдолтой.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Нийцэж буй.
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх,	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.

	ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Нийцэж буй.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Нийцэж буй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Хариуцлагын тогтолцоо сайжирна.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Хувилбар 0	Үгүй	Хязгаарлалт тогтоохгүй
		Хувилбар 1	Үгүй	Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой.

	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Хувилбар 0	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Хяналтыг сайжруулах тул.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 0	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Хувилбар 0	Үгүй	Тусгаагүй.
		Хувилбар 1	Үгүй	Тусгаагүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний үнэлгээний зорилго нь тухайн зохицуулалтын хувилбар нь өсөлт, ажил эрхлэлт, бизнес, өрсөлдөх чадвар болон нийтийн баялагт хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг тогтооход оршино. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг шууд болон шууд бус үр нөлөө гэж ангилагдана. Шууд үр нөлөөний энгийн жишээ бол зохицуулалтын хувилбарын улмаас улсын болон орон нутгийн төсөвт нэмэлт зардал үүсэх, аж ахуйн үйл ажиллагааны татварын хэмжээг өөрчлөх зэрэг байж болно.

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	-
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Хуулийн этгээдэд мэдээлэх үүрэг хүлээлгэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх.	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	салбарт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй учир улсын төсөвт нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Тийм	Хууль батлан гаргах болон хуулийн хэрэгжилтийг хангахад хууль бус хөрөнгийг төр хураана
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Хууль бус хөрөнгийг хураан авах нь эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.

		Хувилбар 1	Тийм	Холбогдох олон улсын гэрээний хэрэгжилт хангагдаж байгаа.
--	--	------------	-------------	---

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах асуудал нь эдийн засагтай хамаарал бүхий юм. Зохицуулалтын хувилбар 1 болон 2 аль аль нь инноваци болон судалгаа шинжилгээ, өмчлөх эрх, хэрэглэгч болон гэр бүлийн төсөв, дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдалд сөрөг болоод эерэг нөлөө үзүүлэхээргүй байна. Мөн мэдээлэх үүргийн улмаас хуулийн этгээдэд захиргааны зардлын ачаалал үүсэхгүй.

Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй учир эдийн засагт үзүүлэх үр нөлөө илүү бага. Харин зохицуулалтын хувилбар 2 нь хууль батлан гаргах болон хуулийн хэрэгжилтийг хангахад нийтийн албан тушаалтнаас хууль бус хөрөнгийг төрд хураан авах нь улсын төсвийг нэмэгдүүлэх шууд үзүүлэх эерэг үр нөлөөтэй.

Эдийн засгийн өсөлтийн гол эх үүсвэрүүдийн нэг болох хөрөнгийн орох урсгалыг нийтийн албан тушаалтнаас хууль бус хөрөнгийн хураан авах нь манай улсын эдийн засагт эергээр нөлөөлж, төгрөгийн ханш огцом сулрах, үнийн өсөлтийг өндөр түвшинд хүргэх, мөн төсвийн орлого тасалдах эрсдэлээс тодорхой хэмжээгээр хамгаалж чадна.

Хууль ёсны байдал сайжирснаар хүний эрхийг хамгаалахад чухал нөлөөтэй ба холбогдох олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг болох тул гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулахад эергээр нөлөөлөх ба санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэж макро эдийн засгийн хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой гэж үзлээ.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэ хэсэгт зохицуулалтын хувилбаруудын нийгэмд үзүүлэх үр нөлөөг авч үзсэн болно. Нийгэмд үзүүлэх үр нөлөө нь үндсэн шинжийн хувьд олон хэлбэрийг агуулдаг бөгөөд өөр хоорондоо болон бусад төрлийн үр нөлөөтэй давхцах нь бий. Доорх хүснэгтэд нийгэмд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд дэлгэрэнгүй буюу нэмэлт тайлбарыг тухайлан бичсэн болно.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийн талаар прокурор шүүхэд нэхэмжлэл гаргаж хяналтын шинэ процедур бий болно.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Прокурорын эрх үүрэгт өөрчлөлт гарна.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэхээс сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Гадаадын иргэдэд илэрхий нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг,үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хяналтыг шинээр бий болгож байгаа.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.

	байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Нийтийн албан тушаалтны хууль бус орлогыг хураах нь аюулгүй байдлын салбарт эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Нийтийн албан тушаалтны хууль бус орлогыг хураах нь албадан хэрэгждэг онцлогтой.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Тийм	Нийтийн албан тушаалтны хууль бус орлогыг хянан шийдвэрлэх явцад үйлдэгдсэн гэмт хэргийг хяналт, шалгалтын үр дүнд илрүүлэх боломжтой.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	-	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Зохицуулалтын хувилбар 1 болон 2 аль аль нь соёл, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг болоод эерэг нөлөө үзүүлэхээргүй байна.

1. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх

Зохицуулалтын хувилбар 1 нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хураах ажиллагааг эрх зүйн зохицуулалтад шинээр зохицуулалт хийхээс татгалзах учир одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Иймд ажлын стандарт, хөдөлмөрлөх эрхэд шинээр нөлөөлөл үүсгэхгүй.

Зохицуулалтын хувилбар 2 нь Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хураах ажиллагааг прокурор шүүхээр шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гаргах нь шинээр бий болох учир ажлын стандарт, хөдөлмөрлөх эрхэд нөлөө үзүүлнэ.

Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх тухайд, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах ажиллагааг шүүхээр шийдвэрлэж шаардлага шинээр тогтоогдох ёстой. Үүнтэй холбоотойгоор ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх ба хэрхэн нөлөөлөх нь хяналтыг хэрхэн тавихтай шууд холбоотой учир дэлгэрэнгүй тайлбарлах боломжгүй.

Шинээр ажлын стандарт гаргах эсэх тухайд, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах ажиллагааг шүүхээр шийдвэрлэх болсноор хяналтын шинэ процедур бий болж түүнд тавигдах чанар, стандарт шинээр тогтоогдоно. Өмнөх бүлгүүдэд дурдсанчлан Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах ажиллагааг шүүхээр шийдвэрлэх нь манай улсад бий болж буй шинэ хяналтын тогтолцоо учир үйл ажиллагаатай нь холбоотойгоор шинэ зохицуулалт бий болгох нь зайлшгүй болно. Харин ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрчлөлт бий болгохыг шаардахгүй.

2. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал

Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх тухайд Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлэх хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн билээ. Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгчдөхгүй. Харин зохицуулалтын хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэхээс сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн тус хувилбарыг хэрэгжүүлснээр тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин эрх нь зөрчигдсөн хүмүүст эерэг нөлөөтэй. Түүнчлэн тус хувилбарыг хэрэгжүүлэх нь гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөхгүй.

3. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун

Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх тухайд, Монголын Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх мэдэлд нөлөөлөх харилцаа сонгосон хувилбаруудыг хэрэгжүүлснээр үүсэх эсэхийг шалгах ёстой.

Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй тул Засаглалын харилцаанд оролцогчдод шинэ нөлөөлөхгүй. Харин зохицуулалтын хувилбар 2-ийг хэрэгжүүлснээр шүүх эрх мэдэл буюу шүүх хяналт тавих шинэ чиг үүрэг нэмэгдэнэ.

Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй тул төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөхгүй. Зохицуулалтын хувилбар 2-ийг хэрэгжүүлснээр Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах ажиллагааг шүүхээр шийдвэрлэх нь шинэ процедур бий болох учир түүнд хяналт тавих эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаанд нөлөөлөх бөгөөд тухайн хэрэгжилтийг хангах чиг үүрэг холбогдох төрийн байгууллагуудад нэмэгдэнэ.

Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх тухайд, Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.

Зохицуулалтын хувилбар 2-ийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах ажиллагааг шүүхээр шийдвэрлэх нь иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд эерэг нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн байдлыг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй авч үзлээ.

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Энэ хэсэгт зохицуулалтын 1 болон 2 дугаар хувилбар нь дараах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцэж байгаа эсэхийг шалгана.

4.5.1. Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж буй эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэж аливаа хууль тогтоомж, шийдвэр, үйл ажиллагаа Үндсэн хуулийг эх сурвалжаа болгож, үзэл санаа, зарчим, агуулгатай нь зөрчилдөхгүй байх буюу Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг бататган бэхжүүлэхийг үүрэг болгосон. Энэ утгаар тухайлсан асуудлыг шийдвэрлэхээр санал болгож буй дараах хувилбарууд нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэх эсэхийг тогтооно.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”, 16.14-т заасан “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэсэн Монгол Улсын иргэний үндсэн эрхүүдтэй шууд холбогдох тул зохицуулалтын хувилбар нь үүнд нийцсэн байхыг шаардана.

Хууль бус хөрөнгө

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т иргэний хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхийг хамгаалсан тул “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө” гэсэн томъёоллыг тодорхойлох замаар тухайн хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нь Үндсэн хуулийн уг заалтад нийцэх эсэхийг тогтооно.

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар толь бичгүүдэд “Шударгаар” гэж эд хөрөнгийг хуулийн хүрээнд үндэслэлтэйгээр олж авсан, эзэмшсэн, өмчилсөн, өв залгамжилсныг хэлнэ.^[11] “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө”-ийг шударгаар олж авах гэдэг нь хууль ёс, зан суртахууны хэм хэмжээнд нийцсэн аргаар эд юмсын эрх үүсгэхийг хэлнэ. Хууль ёсны дагуу хөдлөх, үл хөдлөх хөрөнгө олж авна гэдэг нь хуульд харшлаагүй аргаар олж авахыг, зан суртахууны хэм хэмжээнд нийцсэн арга гэдэгт уламжлалт ёс заншлын дагуу үл маргах зарчмаар хэрэгждэг эсвэл нуун далдлах санаагүй нээлттэй, ил тод, шударга аргаар эд юмс олж авахыг ойлгоно^[12] гэж тайлбарлажээ. Дүгнэвэл, Үндсэн хуульд хуульд харшлаагүй аргаар олж авсан хөрөнгийг “Шударгаар олж авсан хөрөнгө” гэж тодорхойлж өмчийн эрхийг хамгаалжээ. Иймд, шударга бусаар олж авсан хөрөнгө нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д хамаарч, хамгаалагдах хувийн өмч биш буюу хуульд харшилсан аргаар олсон хөрөнгө байх тул нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлоготой холбогдох эрх зүйн зохицуулалтаас “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө”-ийг тодорхойлно.

Нийтийн албан тушаалтныг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Эрүүгийн хуульд тус тус тодорхойлсон байна. АЭХ, НАНБХАСЗАСЗУСТХ-д нийтийн албан тушаалтанд хамаарах этгээдүүдийг жагсаан хуульчилсан бол Эрүүгийн хуульд “Нийтийн албан тушаалтан”-д эдгээр албан тушаалтнаас гадна байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн, эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг ойлгохоор тусгажээ. Харин нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө гэдгийг тухайлан тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолт хуульд байхгүй тул өмчлөх эрхийг хамгаалсан хуулийг зөрчиж олсон хөрөнгө бүр “хууль бус хөрөнгө” гэдэгт хамаарахаар байна. Хууль ёсны өмчлөгч эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгийг ашиглах, өөр зүйлтэй холих, нийлүүлэх, нэгтгэх, дахин боловсруулах зэргээр захиран зарцуулж бусдын эрхийг зөрчсөн этгээд үүнээс учирсан хохирлыг Монгол Улсын Иргэний хуулийн 492-496 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий этгээдэд нөхөн төлөх үүрэгтэй бол бусдын эд хөрөнгийг шударга бусаар олж авсан, өмчилсөн этгээдийн үйлдэлд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх^[13] эрх зүйн зохицуулалт манай улсад үйлчилж байна. Зохицуулалтын хувилбаруудын нэгдмэл зорилго нь нийтийн албан тушаалтан түүний олсон хууль бус хөрөнгийг хураахад чиглэх тул “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө” гэх ойлголт нь Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.2-д заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгсэл” байна.

Үүнээс дүгнэвэл, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө гэж гэмт хэргийн субъект нь нийтийн албан тушаалтан байхаар заасан гэмт хэргийг үйлдэж (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт “Авлигын гэмт хэрэг”) шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгсэл байна. Иймд Эрүүгийн хуульд зааснаас бусад үндэслэлээр нийтийн албан тушаалтны олсон хөрөнгийг хууль бус хөрөнгө гэж тооцохгүй.

Хууль бус хөрөнгийг хураах

Хувийн өмч нь Монгол Улсын Иргэний эрх зүйн дагуу иргэний болон хуулийн этгээдийн өмчийн хэлбэрээр оршин байдаг.^[14] “Хувийн өмч” хувь этгээдийн ашиг сонирхол шингэсэн, бүрэн эрхэд хамаарах (эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй) хувийн эрх зүйн хэм хэмжээгээр харилцааг нь зохицуулдаг эд юмс байна.^[15]

“Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэж хувийн өмчийн халдашгүй байдлыг хамгаалсан байна. “Хууль бус” эсвэл “хууль ёсны” гэдгийг дан ганц объектив эрхийн агуулгаар авч үзвэл төрөөс эрх зүйт бус, дур зоргын хууль тогтоогоод түүнийг үндэслэн хувийн өмчийг хураах, дайчлан авах бололцоо бүрдэнэ. Хувийн өмчийг зөвхөн нийтлэг эрх ашиг (Үндсэн хуульт байгуулал, бусдын хууль ёсны эрх ашиг, нийгмийн үнэт зүйл, хүний амьд явах эрхийг хамгаалах, улсын аюулгүй байдал, батлан хамгаалах шаардлагыг хангах)-ийг хамгаалах зорилгоос гадуур дур зоргын хуульд тулгуурлан эсвэл эрх мэдлээр

далайлган өмчлөгчийн эрхэд халдаж, өмчлөлийн зүйлээс нь хүчээр салгахыг “хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авах” гэнэ.^[16]

Хураах гэж хууль зөрчсөн этгээдийн эд хөрөнгийг төр, түүний эрх бүхий байгууллага үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж улсын орлогод шилжүүлэхийг хэлнэ. Хувийн өмчийг хураах хууль зүйн үндэслэлийг Монгол Улсын Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заажээ. Хэрэв эдгээр хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хувийн өмчийг хураасан бол хууль бус гэж үзнэ.^[17] Аливаа хөрөнгийг шударгаар олж авсан үед түүнд өмчлөх эрх үүсдэг тул шударга бусаар буюу гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө нь хүний хувийн өмчид тооцогдохгүй. Өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус хөрөнгийг хувийн өмчид тооцох эрх зүйн үндэслэлгүй тул тус хөрөнгийг хуульд заасан үндэслэлээр хураах нь Үндсэн хуульд заасан хувийн өмчийг хамгаалах зарчмыг хөндөхгүй байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэж заасан.

“Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” зарчим нь (1) эрүүгийн хуульд заасан гэм бурууг зөвхөн шүүх тогтооно, (2) шүүхээс өөр ямар нэг этгээд хүний гэм бурууг тогтоох эрхгүй, (3) шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй учраас шүүхийн өмнөх болон шүүхийн зохих шатанд гэм буруутай эсэхийг нотлох, үгүйсгэх үйл баримтыг тэнцүү цуглуулах процесс ажиллагаа учраас гэм бурууг тодорхойлох боломжгүй, үүрэггүй зэргийг агуулдаг. Гэм буруутай эсэхийг тогтоох ажиллагаа нь хууль тогтоох эрх бүхий субъект тогтоосон, хүний эрхэд үндэслэсэн, эрх зүйд захирагдах ёс, эрх зүйн “байх ёстой” шударга процесст тулгуурласан нийтлэг хуулийн дагуу хэрэгжүүлэх тухай юм. Иймээс эрүүгийн хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа хүнд ялыг урьдчилан сонсгох, ялгагдагчаар татах буюу шүүхээс гадуур яллах аливаа процесс нь МУ-ын Үндсэн хуулийн тус зарчимд харшилна.^[18] Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, хохирлыг нөхөн төлүүлэх процесс ажиллагаа нь түүнийг гэм буруутай гэдгийг шүүхээс тогтоосны дараа хэрэгжүүлж болох ажиллагаа гэдгийг анхаарах нь зүйтэй байна.

Дүгнэлт

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн

зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө”, 16.14-т заасан “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэсэн Монгол Улсын иргэний үндсэн эрхүүдтэй шууд холбогдох тул санал болгож буй зохицуулалтын хувилбар нь Үндсэн хуульд нийцсэн эсэхийг “Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж буй эсэх” хэсгээр шалгалаа.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т хуульд харшлаагүй аргаар олж авсан хөрөнгийг “Шударгаар олж авсан хөрөнгө” гэж тодорхойлж өмчийн эрхийг нь хамгаалсан бөгөөд шударга бусаар олж авсан буюу хуульд харшилсан аргаар олж авсан хөрөнгөд өмчлөх эрх үүсэхгүй байх агуулгыг тусгажээ. Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд хууль, зан суртахууны хэм хэмжээнд нийцээгүй аргаар олж авсан хөрөнгийг “хууль бус хөрөнгө” гэж үзсэн байх тул өмчлөх эрхийг хамгаалсан хуулийг зөрчиж олсон хөрөнгө бүр үүнд хамаарах юм. Хууль ёсны өмчлөгч эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгийг ашиглах, өөр зүйлтэй холих, нийлүүлэх, нэгтгэх, дахин боловсруулах зэргээр захиран зарцуулж бусдын эрхийг зөрчсөн этгээд үүнээс учирсан хохирлыг Монгол Улсын Иргэний хуульд заасны дагуу нөхөн төлөх үүрэгтэй бол бусдын эд хөрөнгийг шударга бусаар олж авсан, өмчилсөн этгээдийн үйлдэлд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх^[19] эрх зүйн зохицуулалт манай улсад үйлчилж байна.

Зохицуулалтын хувилбаруудын нэгдмэл зорилго нь нийтийн албан тушаалтан түүний олсон хууль бус хөрөнгийг хураахад чиглэх буюу нэгдүгээрт нийтийн албан тушаалтан байх, хоёрдугаарт хууль бус хөрөнгө байх гэсэн урьдчилсан нөхцөлтэй байна. Иймд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө гэж гэмт хэргийн субъект нь “нийтийн албан тушаалтан байх”-аар заасан гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө, орлого буюу Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.5.2-д заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого”-ыг ойлгохоор байна. Дүгнэвэл, Эрүүгийн хуульд зааснаас бусад үндэслэлээр нийтийн албан тушаалтны олсон хөрөнгийг “нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө”-д хамааруулахгүй. Түүнчлэн хууль бус хөрөнгийг хуульд заасан үндэслэлээр хураан авах нь Үндсэн хуульд нийцэх боловч урьдчилан нийтийн албан тушаалтны гэм буруутай, гэмт хэрэг үйлдсэнийг шүүхээр тогтоосон байхыг заавал шаардана. Энэ нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т заасан “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” зарчимд нийцнэ.

4.5.2. Иргэний эрх зүйд нийцэж буй эсэх

Монгол улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-д “Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна”, 103 дугаар зүйлийн 103.1-д “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана” гэж өмчийн төрлүүдийг тодорхойлж, өмчлөх эрхийг бататгасан. Иймд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай дараах зохицуулалтын хувилбарууд нь иргэний эрх зүйгээр зохицуулагдах харилцаа мөн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

Хувийн өмч ба нийтийн өмч

Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар толь бичигт 5 дугаар зүйлийн 5.2-ыг “Хувь этгээдийн хууль ёсны ашиг сонирхол шингэсэн, бүрэн эрхэд хамаарах (эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй) улсын болон орон нутгийн өмчид үл хамаарах нийтийн ашиг сонирхолд үйлчлэх албагүй, хувийн эрх зүйн хэм хэмжээгээр харилцааг нь зохицуулдаг эд юмс, оюуны бүтээлийг хувийн өмч, улс буюу нийтийн ашиг сонирхол шингэсэн, түүний эрх бүхий этгээдийн мэдэлд хамаарах (эзэмших, ашиглах, итгэмжлэгдсэн хүрээнд захиран зарцуулах эрхтэй), нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр харилцааг нь зохицуулдаг юмс, оюуны бүтээлийг улсын буюу нийтийн өмч гэнэ”^[20] гэж тайлбарласан байдаг. Иргэний хуулийн 99 дүгээр зүйлд зааснаар нийтийн өмч гэдэгт төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн, хувийн өмч нь иргэний болон дундын гэсэн хэлбэртэй байна гэж өмчийн төрлийг тодорхойлсон бөгөөд ИХ-ийн 100 дугаар зүйлийн 100.1-д өмчлөгчийг “Хуульд өөрөөр заагаагүй бол төр, аймаг, сум, нийслэл, дүүрэг, иргэн болон хуулийн этгээд өмчлөгч байна” гэж заасан. Эндээс дүгнэвэл, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө нь нийтийн өмч эсхүл хувийн өмчийн аль байхаас шалтгаалан тус харилцааг иргэний эрх зүйгээр зохицуулах эсэх тухай юм.

Хувийн өмч ба нийтийн өмчийн тухай

Нийтийн өмч байх үндсэн шалгуур бол тухайн харилцааны зорилго нь нийгмийн зохион байгуулалттай хэсэг, бүлэг этгээд (тодорхой субъектын хувьд ялгагдан нэршсэн)-ийн эдийн болон эдийн бус баялгийн шинжтэй хэрэгцээг хангахад чиглэгдсэн, тэдгээр хэсэг бүлгийн нэгдмэл хүсэл зоригийн үндсэн дээр эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломж нь тодорхойлогдож буй харилцаа юм^[21] гэж тайлбарлажээ. Монгол Улсын Үндсэн хуульд “Нийтийн өмч” хэмээх нэр томъёог хэрэглэхдээ дэлхийн нийтийн буюу бүх хүн төрөлхтний гэх агуулгаар бус Монгол Улс хэмээх тусгаар улсад харьяалан нийт олны хөрөнгө гэж үзэж, уг хөрөнгийг тэдний өмнөөс хямгадан эзэгнэх эрхийг төр, орон нутаг, нийгмийн зохион байгуулалттай бусад бүлэгт тусгаар тогтнол, хүний эрхийн чөлөөт байдлын баталгаа болгон оноож болохыг тунхаглан зөвшөөрсөн байна.^[22]

ИХ-ийн 1.2 болон 99 дэх зохицуулалт нь эрх зүйн шинэтгэлийн явцад ҮндХ-ийн хэм хэмжээ МУ-ын ИХ-д тусгалаа олсон эсэх талаар маргаан үүсгэх ёсгүй. Харин хөрөнгө хураах тухай зохицуулалт нь нийтийн эрх зүйн шинжтэй хэм хэмжээ байх ёстой тул хуучин ИХ-аас бүр мөсөн хассан. Дээр дурдсанчлан өмчлөх эрхийг нийтийн эрх зүйн зарим хууль тогтоомжоор зарчмын хувьд хязгаарлаж болно гэж үздэг.

Хууль бус хөрөнгө нь нийтийн өмч эсэх

Төрийн өмч нь төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмчөөс бүрдэх ба эдгээрийг ИХ-ийн 84-т заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх гэж ангилж болно.

Төрийн өмч нь “ төрийн нийтийн зориулалттай өмч”, “төрийн өөрийн өмч”- өөс бүрдэх бөгөөд энэ нь Иргэний хуульд заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөд хуваагдана. “Төрийн нийтийн зориулалттай өмч” гэдэг нь “Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлийг хэлнэ” гэж ТБОНӨтХ – ийн 4-р зүйлийн 4.1. –р хэсэгт хуульчилсан байна. Харин төрийн өөрийн өмч гэдэг нь ТБОНӨтХ – ийн 4 – р зүйлийн 4.2. –р хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж

болох эд хөрөнгө хамаарна. Үүнд: төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө, төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан, төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц, хуульд заасан бусад хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө багтдаг байна.

4.5.3. Иргэний процессын эрх зүйд нийцэж буй эсэх

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хураах, ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдон шийдвэрлүүлэхийн тулд иргэний эрх зүйн харилцаанд хамаарал бүхий байх ёстой.

Иргэний хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр талуудын тэгш эрхийн үндсэн дээр үүсэж, өөрчлөгдөж, дуусгавар болж буй, эдийн болон эдийн бус баялагтай холбоотой бүхий л харилцааг зохицуулна. Тус хууль нь нийтлэг үндэслэлүүд, үүргийн эрх зүйн нийтлэг зохицуулалт, гэрээний эрх зүй, гэрээний бус үүрэг, өв залгамжлал болон олон улсын иргэний эрх зүй гэсэн хэсгүүдээс бүрддэг. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө хураах ажиллагаа нь дээрх харилцаанаас гэрээний бус үүрэг буюу үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон гэм хорын маргаанд хамаарах магадлалтай юм.

Иргэнлэг эрх зүйн тогтолцооны ихэнх улс орнуудын хувьд аливаа этгээд хууль болон гэрээнд заасан үндэслэлгүйгээр, бусдын зардлаар хөрөнгөжсөн бол буцаан төлөх ёстой гэсэн ерөнхий зарчимд суурилан үүргийг ногдуулдаг. Энэ утгаараа гэрээний болон гэм хор учруулснаас үүсэх үүргийн дараа орох гурав дахь гол үүргийн төрөл болдог бөгөөд **“хууль болон гэрээнд заасан үндэслэлгүй”, “бусдын зардлаар хөрөнгөжсөн байх”** гэсэн 2 гол нөхцөлийг тавьдаг.^[23] Манай улсын Иргэний хуулийн 492-496 дугаар зүйлд “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэдгийг тодорхойлсон суурь зарчмыг тодорхой тусгаагүй боловч 492 дугаар зүйлд бусдын хөрөнгийг үндэслэлгүйгээр олж авсан, эзэмшсэн, 495 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулсан, 496 дугаар зүйлд бусдын зардлаар болон өөрийн хөрөнгийг хэмнэх аргаар хөрөнгө олж авсан этгээдээс хөрөнгөө буцаан шаардах зэрэг нэхэмжлэгчийн эрхийн хэлбэрүүдийг тусгасан байна.^[24]

Эдгээр зохицуулалт нь холбогдох эзний зөвшөөрөлгүй, хууль бусаар олж авсан хөрөнгийг буцааж эзэнд нь олгох зорилготой бөгөөд Ромын эрх зүйн “condictio” хэмээх эрх зүйн арга хэрэглүүрээс үүдэлтэй. Энэ зарчмын дагуу аливаа хөрөнгийн эрх зөвхөн түүний эзний зөвшөөрлийн үндсэн дээр л бусдад шилжих боломжтой бөгөөд ингээгүй тохиолдолд шилжүүлгийг эрх зүйн үндэслэлгүй гэж үзэх тул тус хөрөнгийг эзэнд нь буцаан олгох ёстой болдог. Үндсэндээ бусдын хөрөнгийг шилжүүлж авсан этгээд нь хөрөнгийн эзний зөвшөөрлийг үүргийн суурь хэлцлийн хэлбэрээр аваагүй, зөвшөөрөл олгосон ч энэ нь хүчин төгөлдөр бус бол тэрээр хөрөнгийг эзэнд нь буцааж өгөх үүрэгтэй хэмээн энд тусгасан. **Энэ нь шууд утгаараа оролцогчдын хооронд хийгдсэн хэлцэл ИХ-ийн 56-д заасан үндэслэлээр анхнаасаа хүчингүй (үүрэг үүсээгүй); эсвэл талууд харилцан тохиролцож үүргээс чөлөөлсөн (дуусгавар болсон) болон хэлцэл ИХ-ийн 58-60, 57.2-т зааснаар хүчин төгөлдөр бус болсон гурван тохиолдлыг хамарч байна.** Мөн эдгээрээс гадна ИХ-ийн 492.1.1-д буй үүрэг үүсээгүй, хөрөнгө олж авсан гэсэн хэсгийг утга зүйн үүднээс тайлбарлавал хөрөнгийг хэлцлийн үндсэн дээр шилжүүлснээс гадна бусад байдлаар шилжсэн тохиолдлыг хамрах нь харагддаг.

Хүчингүй гэрээг хүчинтэй гэж үзсэний үндсэн дээр хөрөнгө шилжүүлсэн болон ерөөсөө хэлэлцээр хийгдээгүй, хоёр тал уулзаагүй байхад хөрөнгө нь ямар нэг байдлаар бусдад шилжсэн хоёр тохиолдол практик амьдралд ялгаагүй эрх зүйн үүднээс ч ИХ-ийн 492-ын үг хэллэгт тусгагдсан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэх нэг тохиолдол юм. ИХ-ийн 492.1-ийн дагуу бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх зорилгоор хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд нь **суурь хэлцэл хүчингүй бол** энэхүү хөрөнгөө буцааж авах эрхтэй гэсэн байна. ИХ-ийн 492.1 нь бүлгийн үндсэн зохицуулалт бөгөөд нэхэмжлэгч (II) хариуцагчийн шилжүүлгийн улмаас (III) үндэслэлгүйгээр (I) хөрөнгө олж авсан байхыг шаардах тул урьдчилсан нөхцөлийг үүний дагуу тодорхойлдог.^[25]

Үүнээс харахад, Иргэний хуулийн үндэслэлгүй хөрөнгөжих нь хууль болон гэрээнд заасан суурь хэлцэл хүчингүй, талууд харилцан тохиролцож үүргээс чөлөөлсөн, бусдын зардлаар хөрөнгөжсөн, хөрөнгийн эзний зөвшөөрлийг үүргийн суурь хэлцлийн хэлбэрээр аваагүй, зөвшөөрөл олгосон ч энэ нь хүчин төгөлдөр бус бол тэрээр хөрөнгийг эзэнд нь буцааж өгөх үүрэгтэй байна.

Эрүүгийн хуульд Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол үндэслэлгүйгээр нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.^[26] гэж тодорхойлсон ба эрүүгийн хуулийн үндэслэлгүйгээр хөрөнгөжих болон иргэний хуулийн үндэслэлгүйгээр хөрөнгөжихийн ялгааг харвал:

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэхэд суурь хэлцэл нь хүчин төгөлдөр бус буюу хуульд заасан үндэслэлгүй, бусдын зардлаар хөрөнгөжсөн байхыг шаардана. Үүнээс үзэхэд дээрх нөхцөлүүдийг хангасан мөн гэмт хэргийн бус хэлцлийн үндсэн дээр бий болсон харилцаа байх ёстой.

Хүснэгт 10. Иргэний болон Эрүүгийн хуульд заасан холбогдох зохицуулалтын харьцуулалт

Эрүүгийн хууль дахь үндэслэлгүй хөрөнгөжилтийн талаар	Иргэний хууль дахь үндэслэлгүй хөрөнгөжилтийн талаар
Ялгаатай шинж	
Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.	Эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
Эрүүгийн хэрэг яллах ажиллагаагаар тодорхойлогдож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу хэрэгжинэ.	Нэхэмжлэлийг хэлэлцэх хэлбэрээр илэрч, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын дагуу хэрэгжинэ.
Эрүүгийн ял шийтгэл оногдуулна (хорих, торгох, хөрөнгө хураах)	Гэрээний дагуу үүсэх үүргийн харилцааг мөнгөн дүнгээр хариуцна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн тохиолдолд хууль бус хөрөнгийг төр хураана .	Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр бус болж өгсөн авсанаа буцаадаг .
Субъект	
-Нийтийн албан тушаалтан Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал; улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан; Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч; бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч; эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан; Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн	Хувь хүн болон хуулийн этгээд.

Иргэний хууль болон Эрүүгийн хууль дахь үндэслэлгүйгээр хөрөнгөжихийн ялгаа нь тус хуулиудын зорилгоос эхлэлтэй юм. Эрүүгийн хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршдог. Гэтэл иргэний хуулиар иргэн, хуулийн этгээдийн хоорондын эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулдаг. Үүнээс үзвэл, эрүүгийн хуулийн үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой зохицуулалт нь илүүтэй тухайн төрийн байгууллагын нийтийн албан тушаалтан хууль бус аргаар хөрөнгө олж авсан гэмт хэргийн үйлдлийг шийтгэхэд чиглэдэг. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн гипотезийг “Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэн нь үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол ...” гэж заасан. Энэхүү гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг буюу Авлигын гэмт хэрэгт хамаарахыг харгалзаж үзэхээс гадна жил бүр хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий нийтийн албан тушаалтан субъект нь байдаг онцлогтой.

Эрүүгийн хуулийн дагуу үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэдэгт нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгээ үндэслэл бүхий тайлагнаж чадаагүй буюу хууль ёсны дагуу олсон

болох нь баримтаар тогтоогдохгүй байх явдлыг ойлгож байна.^[27] Харин иргэний хуулийн үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэдэгт Хувь хүн болон хуулийн этгээдийн хооронд хийгдсэн хэлцэл Иргэний хуулийн хүчин төгөлдөр бус болон хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл бүхий харилцаа үүссэн байхыг хэлдэг.

Үүнээс харахад иргэний эрх зүйн харилцаа нь зөвхөн талуудын тэгш эрхийн үндсэн дээр хувь хүн болон хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцаа байдаг бөгөөд зөвхөн нийтийн албан тушаалтанд энэхүү асуудал нь хамаарна гэсэн онцгойлон тусгасан субъективд хамааруулсан харилцааг зохицуулдаггүй.

Мөн ИХ-ийн үндэслэлгүй хөрөнгөжихөд хэлцэл хүчингүй болж Иргэний хуулийн “56.5.Энэ хуулийн 56.1-д заасан хэлцэл хийсэн талууд нь уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй” гэж тусгасан нь өгсөн авснаа буцаах үр дагавар үүсдэг ба хөрөнгийг төр хураан авах харилцаа байдаггүй.

Түүнчлэн ЭХ-ийн залилах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан бол, Иргэний хуулийн хуурч мэхэлж хийсэн хэлцлээр ИХ-д шийдвэрлүүлж болох тухай асуудал үүсэх боломжтой байна. Үүнээс салбар хоорондын ялгаатай харилцааг зохицуулдаг хэлбэр алдагдах боломжтой зэрэг асуудлууд үүсэх боломжтой байна.

Тиймээс энэхүү зохицуулалт нь Иргэний хуульд заасны дагуу үүргийн хэлцэл дуусгавар болсон, хүчин төгөлдөр бус болсны улмаас үндэслэлгүйгээр бусдад шилжүүлсэн эд хөрөнгөө буцаан шаардахаас зорилго, субъект болон эрх зүйн үр дагавраараа ялгаатай болно.^[28] Энэ нь Хувилбар 1-ийн хүрээнд нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгөөс үүдэлтэй харилцааг зохицуулах салбар эрх зүйгээр шийдвэрлэх нь илүү оновчтой юм.

4.5.4. Захиргааны эрх зүйд нийцэж буй эсэх

Захиргааны эрх зүй нь Үндсэн хуулийн эрх зүй болон Эрүүгийн эрх зүйгээс бусад нийтийн эрх зүйг хамарсан өргөн цар хүрээ бүхий салбар бөгөөд гол судлагдахуун нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй захиргааны байгууллага, албан тушаалтны иргэн, хуулийн этгээдтэй харилцах эрх зүйн харилцаа юм.

Захиргааны ерөнхий хуулийн /цаашид “ЗЕХ” гэх/ Аравдугаар бүлэгт захиргааны байгууллага, албан тушаалтан нь өөрийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа иргэн, хуулийн этгээдэд бодитой хохирол учруулсан бол түүнийг арилгах, шаардлагатай нөхөн олговрыг олгох талаар зохицуулжээ. Ингэхдээ хохирлыг:

- Хууль ёсны үйл ажиллагааны улмаас үүссэн хохирол;
- Хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн хохирол хэмээн 2 ангилсан байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль ёсны үйл ажиллагааны улмаас учирсан хохирол гэдэг нь төрөөс нийтийн ашиг сонирхлын төлөө иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхэд хуульд үндэслэн, нөхөн олговортойгоор халдах тухай юм. Өөрөөр хэлбэл төрөөс иргэний өмчлөх эрхэд халдаж байгаа тохиолдолд тухайн иргэн хохирох ёсгүй бөгөөд хохирлыг нөхөх олговроор арилгах зарчмыг баримтлах ёстой.

Харин хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн хохирол гэдэг нь захиргааны байгууллага, албан тушаалтны хууль зөрчсөн буруутай үйл ажиллагаа, шийдвэрийн улмаас

иргэн, хуулийн этгээдэд хохирол учрахыг ойлгох бөгөөд дараах урьдчилсан нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Үүнд:^[29]

- а) Захиргааны байгууллага, албан тушаалтны нийтийн эрх зүйн харилцааны хүрээнд үүссэн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй байх;
- б) Шаардах эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь зөвхөн захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон этгээд байх;
- с) Учирсан хохирол нь материаллаг бөгөөд тухайн захиргааны үйл ажиллагааны улмаас шууд учирсан бодитой хохирол байх;

Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр барагдуулж, үүний дараагаар төр өөрт учирсан хохирлоо (=тухайн хохирлыг барагдуулсан нөхөн төлбөрийг)Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.” гэж заасны дагуу буруутай захиргааны байгууллага, албан тушаалтнаас буцаан шаардах эрхтэй.^[30] Энэ нь төрийн албан хаагч дахин хууль бус шийдвэр гаргахаас сэргийлэх, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулахгүй байх зорилготой юм.

Дээрх зохицуулалтыг нийтийн албан тушаалтны хууль бусаар хөрөнгө, орлого олсон тохиолдолд хэрэглэж болох эсэхийг судлан авч үзье.

Захиргааны ерөнхий хууль нь захиргааны байгууллагын захирамжилсан шийдвэр, үйл ажиллагаа болон түүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг зохицуулсан материаллаг хууль тул нийтийн албан тушаалтны хууль бусаар хөрөнгө, орлого олсон тохиолдолд ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэглэхийн өмнө нийтийн албан тушаалтан нь захиргааны байгууллага мөн эсэхийг шалгах шаардлагатай.

ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан тодорхойлолтоос үзвэл нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргаж буй нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэнэ. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг болон Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд тус тус зааснаар нийтийн албан тушаалтан нь нийтийн эрх зүйн хүрээнд тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэн захирамжилсан шийдвэр гаргах нийтийн эрх зүйн этгээд байх тул ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллага мөн юм.

Иймээс нийтийн албан тушаалтны хууль бусаар хөрөнгө, орлого олсон үйлдэл нь ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт заасан урьдчилсан нөхцөлийг хангаж буй эсэхийг шалган үзье.

1. *Захиргааны байгууллага, албан тушаалтны нийтийн эрх зүйн харилцааны хүрээнд үүссэн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй байх;*

Захиргааны байгууллагын үйл ажиллагаа дахь хууль бус үйлдэл болон эс үйлдэхүй гэдэгт тухайн захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны акт болон захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нь холбогдох хуулийг зөрчсөн байхыг ойлгоно. Гэтэл

дээрх тохиолдолд хэрэв нийтийн албан тушаалтан нь хууль бус захиргааны акт болон шийдвэр гаргасны үндсэн дээр хөрөнгө, орлого олсон бол энэ нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг агуулах тул тус урьдчилсан нөхцөлийг хангахгүй гэж үзэв.

2. Шаардах эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь зөвхөн захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон этгээд байх;

Энэ тохиолдолд хэрэв нийтийн албан тушаалтан нь хууль бус захиргааны акт болон шийдвэр гаргасны үндсэн дээр хөрөнгө, орлого олсон бол иргэн, хуулийн этгээдэд бодитой хохирол учрах тул шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжтой.

3. Учирсан хохирол нь материаллаг бөгөөд тухайн захиргааны үйл ажиллагааны улмаас шууд учирсан бодитой хохирол байх;

Хэрэв нийтийн албан тушаалтан нь хууль бус захиргааны акт болон захиргааны шийдвэр гаргасны үндсэн дээр хөрөнгө, орлого олсон бөгөөд энэ эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг агуулаагүй бол иргэн, хуулийн этгээдэд бодитой хохирол учирсан гэж үзэж болох юм.

Дээрхээс товч дүгнэвэл, нийтийн албан тушаалтан нь ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллага мөн хэдий ч хууль бус захиргааны акт болон шийдвэр гаргасны үндсэн дээр хөрөнгө, орлого олсон нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг агуулж байх тул ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэглэх нь тохиромжгүй гэж үзлээ.

ЗЕХ-ийн Арван нэгдүгээр бүлэгт захиргааны байгууллага, албан тушаалтан нь өөрийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа илтэд хууль зөрчсөний улмаас иргэн, хуулийн этгээдэд бодитой хохирол учруулсан бол түүний зөрчлийн шинж байдлыг харгалзан хариуцлага ногдуулах талаар зохицуулжээ.

Ийнхүү хуульчлахдаа зөрчлийн улмаас учирсан хохирлын хэмжээ, гэм буруугийн санаатай хэлбэр, зөрчил бүхий үйлдлийн давталт, чиг үүрэг, хариуцлагаа ухамсарлаагүй буюу биелүүлээгүй байдал зэрэг нөхцөл, шинжийг харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тухайн зөрчил үйлдсэн албан тушаалтныг томилсон албан тушаалтан, эсхүл дээд шатны байгууллага дараах хариуцлагыг ногдуулахаар заасан байна. Үүнд:

- хууль биелүүлж ажиллахыг хаалттай болон нээлттэй сануулах;^[31]
- албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;^[32]
- ажлаас халах;^[33]
- нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;^[34]

Зөрчил гаргасан албан тушаалтныг томилсон албан тушаалтан, эсхүл дээд шатны байгууллага нь дээр дурдсан хариуцлагыг ногдуулахдаа харгалзах нөхцөл, шинжийг холбогдох нотлох баримтыг бүрдүүлсний үндсэн дээр нэг бүрчлэн судалж, ямар шийтгэл оногдуулсан болохоо тухайн шийтгэл ногдуулж буй хууль бус захиргааны акт, эсхүл захиргааны шийдвэрт үндэслэн тайлбарлах ёстой.^[35]

Гэтэл нийтийн албан тушаалтан хууль зөрчсөн захиргааны акт, эсхүл захиргааны шийдвэр гаргасны үндсэн дээр хөрөнгө, орлого олсон нь Эрүүгийн хуулиар зохицуулагдах харилцаа байхаас гадна ЗЕХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсэгт хууль бусаар олсон

эдийн болон эдийн бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх хариуцлагын талаар зохицуулаагүй байна.

1992 оноос хойш Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 230 гаруй хууль тогтоомжид захиргааны хариуцлага ногдуулах талаар заасан бөгөөд 2017 оны Зөрчлийн тухай хууль нь тэдгээр хуулиудад заасан захиргааны зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг төрөлжүүлэн нэгтгэсэн анхны кодификаци хууль юм.^[36]

Зөрчлийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого болон зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг албадан хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг буруутай этгээдээс гаргуулах, хор уршгийг арилгах талаар зохицуулсан бөгөөд эдгээр албадлагын арга хэмжээг Зөрчлийн тухай хуулиар тодорхойлсон, зөрчил үйлдсэн иргэн, хуулийн этгээдэд ногдуулна. Өөрөөр хэлбэл иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйлдлийг зөрчлийн тухай хуулиар тодорхойлоогүй, зөрчил гэж үзээгүй бол тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй.

Энэ хүрээнд авч үзвэл нийтийн албан тушаалтны хууль бусаар хөрөнгө, орлого олсон үйлдэл тэр дундаа авлига, албан тушаалын гэмт хэргийг үйлдэж олсон эдийн болон эдийн бус хөрөнгө, орлогыг албадан хураах нь Эрүүгийн хуулиар зохицуулах харилцаа байх тул Зөрчлийн хуульд заасан хөрөнгө, орлогыг хураах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлгүй юм.

Эдгээрээс дүгнэвэл,

1. Захиргааны ерөнхий хуулийн Аравдугаар бүлэгт захиргааны байгууллага, албан тушаалтан нь өөрийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа иргэн, хуулийн этгээдэд бодитой хохирол учруулсан бол түүнийг төр барагдуулж, үүний дараа төр өөрт учирсан хохирлоо ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” гэж заасны дагуу буруутай захиргааны байгууллага, албан тушаалтнаас буцаан шаардах эрхтэй. Уг зохицуулалтыг нийтийн албан тушаалтны хууль бусаар хөрөнгө, орлого олсон тохиолдолд хэрэглэж болох эсэхийг судлан авч үзэхэд нийтийн албан тушаалтан нь ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллага мөн хэдий ч түүний хууль бус захиргааны акт болон шийдвэр гаргасны үндсэн дээр хөрөнгө, орлого олсон үйлдэл нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг агуулах тул ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэглэх нь тохиромжгүй байна.

2. Захиргааны ерөнхий хуулийн Арван нэгдүгээр бүлэгт захиргааны байгууллага, албан тушаалтан нь өөрийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа илтэд хууль зөрчсөний улмаас иргэн, хуулийн этгээдэд бодитой хохирол учруулсан бол түүний зөрчлийн шинж байдлыг харгалзан хариуцлага ногдуулах талаар зохицуулсан байх боловч хүлээлгэх хариуцлагад хууль бусаар олсон эдийн болон эдийн бус хөрөнгийг хураах, нөхөн төлүүлэх хариуцлагын талаар зохицуулаагүй байна.

3. 2017 оны Зөрчлийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого болон зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг албадан хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг буруутай этгээдээс гаргуулах, хор уршгийг арилгах талаар

зохицуулсан. Гэтэл нийтийн албан тушаалтны хууль бусаар хөрөнгө, орлого олсон үйлдэл тэр дундаа авлига, албан тушаалын гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг албадан хураах нь Эрүүгийн хуулиар зохицуулагдах харилцаа байх тул Зөрчлийн хуульд заасан хөрөнгө, орлогыг хураах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлгүй юм. Иймээс нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон буюу хууль ёсны эх үүсвэр нь тодорхойгүй эдийн болон эдийн бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нь Эрүүгийн хуулиар зохицуулах харилцаа байх тул Захиргааны эрх зүйд хамаарахгүй, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсэхгүй гэж дүгнэлээ.

4.5.6. Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж буй эсэх

Хууль бус хөрөнгийг илрүүлэх, нотлох, хариуцлага хүлээлгэх ажиллагаа нь үндэстэн дамнасан гэмт хэргийн шинжийг түгээмэл хэлбэртэй агуулах тул олон улсын хамтын ажиллагааг нягт шаардах төлөвтэй байдаг. Иймд авлигатай тэмцэх, хууль бус хөрөнгийг илрүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хэрэгжүүлж буй олон улсын хамтын ажиллагааны механизм, хориг арга хэмжээтэй холбоотойгоор батлагдан хэрэгжүүлж буй гэрээ, конвенцуудад хууль бус хөрөнгийг илрүүлэх, хураах, буцаахтай холбоотой ойлголтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусган оруулсан байдаг. Иймд Монгол Улсын нэгдэн орсон авлигын эсрэг олон улсын гэрээнд тусгагдсан агуулгуудаар ...-ыг шалгана.

Олон улсын түгээмэл шинжтэй Авлигын эсрэг олон улсын гэрээнд дараах гэрээ, конвенцууд багтана. Эдгээр нь:

1. НҮБ-ын Авлигын эсрэг конвенц-2004
2. Эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллагын Хээл хахуулийн эсрэг конвенц-1997
3. Европын Зөвлөлийн Авлигын талаарх эрүүгийн эрх зүйн конвенц-1999
4. Европын Зөвлөлийн Авлигын талаарх иргэний эрх зүйн тухай конвенц-1999 зэрэг конвенцуудыг түгээмэл шинжтэй авлигын олон улсын гэрээнд хамааруулан авч үздэг.

Эдгээрээс Авлигын эсрэг конвенцыг НҮБ-ын Ерөнхий Асамблейн хурлаар 2003 онд баталсан бөгөөд манай улс уг конвенцыг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан. Уг олон улсын гэрээгээр Монгол Улс нь авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын хэргийг гэмт хэрэгт тооцох, олон улсад хамтран ажиллах, хөрөнгө буцаах, техникийн туслалцаа мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах үүрэг хүлээдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасны дагуу конвенцын хэрэгжилтийг биелүүлэх үүргийг хүлээнэ. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр/2023-2030/ Зорилт 6.1-т Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг бүрэн хангана, 6.1.4 заалтад Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ, Зорилт 6.3-т Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бүрдүүлнэ гэж тус тус заасан байна. Иймд конвенцын заалт дахь хууль бус хөрөнгийг түр хураах, хураахтай холбоотой

зохицуулалтын тодорхойлолтуудыг шинжилж, олон улсын хамтын ажиллагаатай холбоотой хэсгийг авч үзнэ.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенц

Уг конвенцын 31 дүгээр зүйлд битүүмжлэх, түр хураах, хураах гэсэн ойлголтуудыг томъёолж, уг ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой заалтуудыг тусгасан бөгөөд “оролцогч улс бүр дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд аль болох өргөн хэмжээнд дараах зүйлийг хураах болоход шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

А) энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлого буюу тийм орлогын үнийн дүнтэй тохирох эд хөрөнгө,

В) энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсхүл ашиглах зорилготой эд хөрөнгө тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийн эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгсэл.”^[37] гэж заасан байна.

Иймд тус конвенцод нэгдсэн 170 гаруй улс орнуудын хувьд авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй хамааралтайгаар хууль бусаар олж авсан орлогыг хураахтай холбоотой дотоодын эрх зүйн зохицуулалтыг шаардлагатай хэмжээнд хуульчлан тогтоох нь зүйтэй гэсэн байна. Түүнчлэн конвенцын нэр томъёотой холбоотой заалтад битүүмжлэх болон түр хураах/freezing or seizure/ ажиллагааг “шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг шилжүүлэх, солих, захиран зарцуулах, хөдөлгөхийг түр хугацаагаар эзэмшил буюу хяналтад авах”^[38], хураах/confiscation/ ажиллагааг “хэрэглэх эрхийг оруулан, шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авах”^[39] гэж тус тус ялгаатай хэлбэрээр тодорхойлсон байна. Мөн конвенцын 31 дүгээр зүйлийн хэрэгжилтийг биелүүлэхтэй холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

1. Авлигын гэмт хэргээс олсон орлогыг өөр хэлбэрийн хөрөнгө болгон шилжүүлсэн, хувиргасан тохиолдолд хохирол учруулсан хэмжээний хөрөнгө орлогыг битүүмжлэх, хураах арга хэмжээг авах
2. Хууль бус хөрөнгийг хууль ёсны хөрөнгөтэй хольсон тохиолдолд холилдсон хэсгийн үнийн дүнгийн хэмжээгээр нь битүүмжлэхэд буюу түр хураахад хамаарах аливаа эрх мэдлийг үл хөндөн түр хураах
3. Конвенцын хөрөнгө хураах, битүүмжлэхтэй холбоотой 31 дүгээр зүйлийн заалтууд нь шударга гуравдагч тал/bona fide third parties/-ын эрхийг хөндөх агуулгаар тайлбарлагдахгүй.
4. Эд хөрөнгийг хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагааны хүрээнд оролцогч улс бүр банк, санхүү буюу худалдааны тэмдэгтийг гаргаж өгөх буюу түр хураах шийдвэр гаргах эрхийг өөрийн шүүх буюу бусад эрх бүхий байгууллагад олгоно. Оролцогч улс банкны нууцлал гэсэн шалтгаанаар тухайн ажиллагааг ил болгохоос зайлсхийх ёсгүй.

зэрэг хэрэгжүүлэх зохицуулалтын хэлбэрийг тусгажээ. Үүнээс “хууль бус орлого”, “хууль бус орлогоос бий болсон хөрөнгө” гэсэн нэр томъёонуудыг тодорхойлохдоо Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 31 дүгээр зүйлийн 4,6 дахь хэсгийн ойлголтуудтай нийцсэн байдлаар тодорхойлсон боловч 31 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хууль бус хөрөнгийг хууль ёсны хөрөнгөтэй хольсон тохиолдлын зохицуулалтыг нарийвчлах шаардлагатай.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн үнэлгээг 5 жил тутам хоёр гишүүн улсын шинжээчдээс бүрдсэн баг томилогдож гуравдагч улсын конвенцын хэрэгжилтэд үнэлгээ хийдэг. Ингэхдээ конвенцыг бүхэлд нь бус хоёр бүлгийг түүвэрлэн сонгож, тухайн улсын хууль тогтоомж, авлигын нөхцөл байдлын шинжилгээ, үнэлгээний тайлан, тоо баримт, иргэний нийгмийн байгууллагын байр суурь болон бусад шаардлагатай материалыг ашиглан гаргадаг. Монгол Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын III (Авлигын гэмт хэргийг гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах), IV (Олон улсын хамтын ажиллагаа) бүлгийн хэрэгжилтийг 2010 онд Иемен, Кени улсууд, II (Урьдчилан сэргийлэх), V (Хөрөнгө буцаах) бүлгийн хэрэгжилтийг Буркина Фасо, Сингапур Улсууд 2022 онд гаргаж 2023 онд олон нийтэд нээлттэйгээр нийтэлсэн. Тайланд дурдсанаар сүүлийн 2019-2022 оны хугацаанд АТГ-аас улсын төсөвт 5,9 тэрбум төгрөг төвлөрүүлж, 74 иргэн, 37 хуулийн этгээдийг шалгаж, нийт 106,773,000,000 төгрөгийн үл хөдлөх, хөдлөх хөрөнгө битүүмжлүүлсэн байна. Гэвч үүнд хууль бус хөрөнгө орлогоос гадна мөнгө угаасан болон бусад хэлбэрийн санхүүгийн гэмт хэргүүдийн улмаас төвлөрүүлсэн орлого мөн багтжээ.

Уг тайлангийн V бүлэг(хөрөнгө буцаах)-т хийсэн шинжилгээний дүгнэлтийн хүрээнд: *Монгол Улс олон улсын хамтын ажиллагаа, эд хөрөнгийг эргүүлэн авах хүсэлт гаргахад зориулсан хэргийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх нь зүйтэй.*^[40] гэсэн бөгөөд **Монгол Улсад дараах зөвлөгөөг хэрэгжүүлэхийг зөвлөсөн нь:**

1. *Монгол Улс шаардлагатай үед хурааж авсан эд хөрөнгийг захиран зарцуулах гэрээ, хэлэлцээрийг тухайн тохиолдол бүрээр байгуулж болох ч өнөөдрийг хүртэл тийм ажиллагаа хийгээгүй.*
2. *Гэмт этгээд нас барсан, зугтсан, эзгүй болсон шалтгаанаар болон бусад холбогдох тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр эд мөрийн баримтаар хураах арга хэмжээг нарийвчлах асуудлыг авч үзэх*
3. *Конвенцын 57 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтын дагуу хөрөнгийг буцаан олгох, захиран зарцуулах механизмыг тодорхой тусгах.*^[41] гэсэн зөвлөмжүүдийг хууль бус хөрөнгө хураах, түүнийг удирдах ажиллагаатай холбоотойгоор гаргасан байна.

ЭЗХАХБ-ын Зүүн Европ, Төв Ази дахь авлигтай тэмцэх ажиллагааны хүрээнд Монгол Улсын авлигын нөхцөл байдлыг шинжлэн, Истбанбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шатны хүрээнд гаргасан тайлангийн дүгнэлтэд “Хураан авах үйл ажиллагаатай холбоотой зарим нэг эерэг өөрчлөлтийг үл харгалзан үүнтэй холбоотой хууль тогтоомжийн зохицуулалтыг цаашид улам бүр боловсронгуй болгох шаардлагатай. Тухайлбал авлигын гэмт хэргийн замаар бий болгосон бөгөөд өөр эх үүсвэр бүхий хөрөнгөтэй холилдсон хөрөнгийг хураан авах ажиллагаа, өртөгт суурилсан хураан авах ажиллагаа, хэргийн талаар мэдэж байсан гуравдагч этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг хураан авах ажиллагааны талаар өөрчлөлт оруулах шаардлагатай.”^[42] гэжээ. Мөн Монгол Улсын авлигын эсрэг орчинд 19 үзүүлэлтээр шинжилгээ хийн үнэлгээ гаргасны дотор Авлигын гэмт хэрэгт ноогдуулах шийтгэл, хөрөнгө хураан авах ажиллагаа гэсэн үзүүлэлтийн нийцлийн үнэлгээг “хагас дутуу” хэмээн үнэлсэн байна. Улмаар тус тайлангийн 21 дүгээр зөвлөмжид:

2. *(Эрүүгийн эсхүл иргэний) өргөтгөсөн хөрөнгө хураан авах ажиллагааг нэвтрүүлж, авлигын гэмт хэрэг үйлдсэн сэжиг бүхий тохиолдол илэрсэн бол нотолгоо гаргах үүргийг хариуцагч талд шилжүүлдэг болох.*

3. Мэдэж байсан гуравдагч талын өмчлөлд байгаа нь тогтоогдсон хөрөнгө (авлигын гэмт хэргээс олсон хөрөнгө орлого, хэрэгсэл тэдгээрийн үр шим)-ийг хураан авах ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэлийг тодорхой болгох^[43]

гэсэн байна.

Мөн тус тайлангийн 25 дугаар зөвлөмжийн 8 дугаар хэсэгт “Хөрөнгө хураах эсхүл хураагдсан хөрөнгийг удирдах чиг үүрэг бүхий тусгай байгууллага эсхүл нэгжийг байгуулах, авлигын гэмт хэргийн гаралтай хөрөнгө орлогыг мөрдөх, тогтоох, хураах, удирдах үр нөлөөтэй журмыг хэрэгжүүлэх”^[44] нь зүйтэй гэсэн зөвлөмжийг мөн өгчээ. Түүнчлэн тус хэсэгт хөрөнгө хураан авах чиглэлээр авлигатай тэмцэх асуудал эрхэлсэн байгууллага, шүүх, прокурорын албан хаагчдад чиглэсэн үе шаттай сургалтыг зохион байгуулж, шаардлагатай мэдэгдэхүүнийг олгоход анхаарахыг зөвлөжээ. Үүнээс үзэхэд авлигын болон хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой Эрүүгийн хуулийн зохицуулалтыг сайжруулахыг ЭЗХАХБ/OECD/-аас зөвлөж, одоогийн авлигатай холбоотой болон хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой эрх зүйн орчны зохицуулалтын хэрэгжилт учир дутагдалтай тул нарийвчлан боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзжээ.

Улмаар хөрөнгө хураах ажиллагаатай холбоотойгоор ерөнхийд нь Монгол Улсад дараах зөвлөмжийг өгсөн нь:

- Авлигын хэрэг бүр дээр гэмт хэргээс үүсэлтэй хөрөнгө орлого, хэрэгсэл, тэдгээрийс олсон ашгийг хураан авахыг тогтолцоог нэвтрүүлэх.
- Онц ноцтой хэмжээний авлигын гэмт хэргийг шалгаж, гэм бурууг тогтоон, гэмт хэргийн үүсэлтэй хөрөнгийг хураан авсан ажиллагааны үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх.
- Авлигын гэмт хэргийн төрөл, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал (хариуцлагын төрөл, гэм буруугийд тооцсон, өршөөсөн тоо), хураан авах ажиллагаа явуулсан тоо (хураан авах ажиллагааны төрөл, хөрөнгийн төрөл (хэрэгсэл, хөрөнгө орлого (шууд болон шууд бус), үр шим), гэм буруутан, хамсаатан, мэдэж байсан гуравдагч тал (хувь хүн, хуулийн этгээд), хураан авсан хөрөнгийн хэмжээ гэх мэт) зэрэг авлига болон мөнгө угаах гэмт хэргийн дэлгэрэнгүй, найдвартай тоон мэдээг тогтмол хэвлэх, шинэчлэхэд шаардлагатай нөхцөл байдлыг хангах.

Үүнээс үзэхэд Монгол Улсад авлигын гэмт хэрэгтэй болон хууль бусаар олсон нийтийн албан тушаалтны орлогыг хураах, учруулсан хохирлыг барагдуулах хуулийн зохицуулалтыг сайжруулахыг зөвлөж, хэрэгжүүлсэн арга хэмжээний болон хөрөнгийн хэмжээний талаар нийтэд мэдээлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг зөвлөсөн байна. Улс хоорондын эрх зүйн тогтолцооны ялгаатай байдал, бүсчлэл, нөөц чадавхын зөрүү зэргээс шалтгаалан мөрдөн шалгах болон хөрөнгө буцаах ажиллагаа нь урт хугацааны процесстой байх, удаашрах төлөв түгээмэл байдаг. Үүнээс гадна тухайн хамтран ажиллаж буй улс оронтой ямар хэлбэрээр хамтран ажиллах тухай ойлголт нь ялгаатай бөгөөд түгээмэл ашиглагддаг үндсэн хоёр хэлбэр нь албан бус туслалцаа болон эрх зүйн харилцан туслалцааны хэлбэр байдаг. Эдгээр хоёр арга хэлбэр нь тус тусын давуу болон сул талтайн дээр хууль бус орлого олсон хэлбэр, хэмжээ, хэргийн явц зэргээс хамаарна.

Улмаар тус тайлангийн дүгнэлтэд “Монгол Улс нь конвенцын 55 дугаар зүйлийн 1 (а) ба 2 дахь хэсэгт дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагатай түвшний арга хэмжээг

хэрэгжүүлээгүй”^[45] гэсэн ерөнхий дүгнэлт хийжээ. Өөрөөр хэлбэл өнөөг хүртэлх Монгол Улсын хууль бус хөрөнгийг хураах, битүүмжлэхтэй холбоотой гадаад улс орнуудтай конвенцын хүрээнд хамтран ажиллах, гадаад улсын хүсэлтийг хүлээн авах, холбогдох арга хэмжээг авах, өөрсдийн хүсэлтийг илгээх, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн зохицуулалтыг хангалтгүй түвшинд гэж үзсэн байна. Монгол Улс нь хууль бус хөрөнгийг буцаах, шалгах, хураахтай холбоотой өөрийн нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу гадаад улс орнуудтай хамтран ажиллах зохицуулалтыг дотоодын хууль тогтоомждоо нарийвчлан зохицуулалтыг тусгаагүй нь хөндлөнгийн үнэлгээ, хяналт хийхэд тухайн чиглэлийн үйл ажиллагаа хангалтгүй гэсэн үнэлгээ авахад нөлөөлжээ. Энэ хэлбэрийн хууль, эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг тусгах нь авлига, хууль бусаар олсон орлогыг илрүүлэх ажиллагаанд ахиц гаргах боломжийг нэмэгдүүлэх давуу талтай. Мөн Авлигын эсрэг НҮБ-ын конвенц нь Монгол Улсын дээд шүүхийн 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоолд заасан 129 олон улсын гэрээ жагсаалтад багтаагүй тул конвенц дахь зарчим, хэм хэмжээний шинжтэй заалтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэхэд хуульд тусгасан зохицуулалт нь давуу талтай байх боломжтой.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 46 дугаар зүйлд авлигын хэрэг болон хууль бус хөрөнгөтэй холбоотой эрх зүйн туслалцаа хүсэхэд дараа зүйлсийг тусгана гэсэн нь:

- шүүхийн баримт бичгүүдийг гардуулах зорилготой хүсэлтээс бусад тохиолдолд холбогдох үйл баримтын товч танилцуулга;
 - нотлох баримт, мэдээлэл буюу арга хэмжээг хүссэн зорилго
 - хүссэн туслалцааны талаарх тодорхойлолт болон мөрдвөл зохино гэж хүсэлт гаргагч оролцогч улсын үзэж буй аливаа тодорхой ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл
- Тусгаж болохуйц зүйл:
- холбогдох аливаа этгээдийн овог нэр, байгаа газар болон иргэний харьяалал

Хууль бус хөрөнгийг хураах ажиллагаа нь авлига, албан тушаалын гэмт хэрэг, мөнгө угаах, хууль бус орлогыг нуун дарагдуулахтай харилцан хамааралтай үйлдэгдэх шинж төлөвтэй байдаг бөгөөд хууль бус хөрөнгө, орлогыг нуун дарагдуулах гэсэн албан тушаалтан нь гадаад улсад хөрөнгөө байршуулах, гарал үүслийг нуун дарагдуулах ажиллагаа идэвхтэй хийгдэх хандлагатай байдаг.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын зөвлөмж /FATF/

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /The Financial Action Task Force FATF/ нь 1989 онд үүсгэн байгуулагдсан олон улсын санхүүгийн зах зээлийн аюулгүй байдлыг хангах, аюул эрсдэл учруулж болзошгүй хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, мөнгө угаах, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, эрх зүйн орчныг тогтоон боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагаас 1990 онд гэмт хэргийн хүрээллийг хар тамхины наймаанд тулгуурласан 40 зөвлөмжийг боловсруулж байсан бөгөөд хамаарагдах гэмт хэргийн хүрээг нэмэгдүүлэн 2003 онд тус зөвлөмжүүдийг шинэчилсэн. Одоогийн байдлаар дэлхийн 180 гаруй улс орон тус 40

зөвлөмжийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт гэж хүлээн зөвшөөрөн^[46] дагаж мөрдөж байна. Монгол Улс нь ФАТФ-ын Ази, номхон далайн бүс нутгийн бүлэгт гишүүнчлэлтэй. Улмаар ФАТФ-ын 40 зөвлөмжийн хэрэгжилтийг хангалттай түвшинд хэрэглээгүй гэсэн үндэслэлээр манай улс 2014 онд “саарал жагсаалт”-д орж байсан удаатай.

ФАТФ-ын үндсэн 40 зөвлөгөө нь мөнгө угаа, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээнээс гадна гэмт хэргээс олсон хөрөнгийг хураан авах тухай агуулга багтсан байдаг. Тухайлбал 4 дүгээр зөвлөмж буюу Хөрөнгө хураах болон түр зуурын арга хэмжээ/*Confiscation and provisional measures*/ хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, ашигласан хэрэгсэл хөрөнгийг эрүүгийн шийтгэлгүй хураах арга хэмжээг улс орнууд боловсруулсан байвал зохино. Эсвэл хураах хөрөнгийг хууль ёсны гаралтай гэдгээ батлахыг гэмт хэрэгтнээс шаардах арга хэмжээг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах хэрэгтэй.” гэж заасан байна. Өөрөөр хэлбэл олон улсын санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгын хүрээнд хууль бус хөрөнгийг хураах ажиллагааг эрүүгийн бус журмаар хураах зохицуулалтыг зөвлөмжийг хэрэгжүүлж буй улс орнууд буй болгох нь зүйтэй гэсэн заалттай байна.

ФАТФ-ын зөвлөмж нь хэдийгээр императив хэм хэмжээгээр заавал биелүүлэх шинж чанаргүй боловч тус байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнүүлсэн улс орнууд “саарал жагсаалт”-д багтсанаар тухайн улсын эдийн засгийн нэр хүнд олон улсын түвшинд унах, санхүүгийн тогтолцоонд хүндрэл учрах, гадаадын зээл тусламж багасах зэрэг сөрөг нөлөөтэй. “Саарал жагсаалт”-д багтсан улс уг жагсаалтаас гарахад 5 хүртэлх жилийг зарцуулж байсан тохиолдлууд байдаг бөгөөд саарал “жагсаалт”-аас гарах арга хэмжээ хэрэгжүүлээгүй улс орнууд “хар жагсаалт”-д орсноор үндсэндээ эдийн засгийн хоригт орж буйтай ялгаагүй санхүүгийн гадаад нөхцөл байдалд хүрдэг байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар ФАТФ-ын “хар жагсаалт”-д БНАСАУ, Мьянмар, Иран гэсэн гурван улс, “саарал жагсаалт”-д Зүүн Өмнөд Ази, Өмнөд Америк, Африкийн бүс нутгийн 24 улс орсон байна.

Хувилбар нэг-Авлигатай холбоотой шүүхээр шийдвэрлэсэн 2019 оны хэргүүдийг авч үзвэл нийт хэргүүдийн 55 хувийг шийдвэрлэсний дотор 62 хувьд нь торгох ял, 15 хувьд нь хорих ял оногдуулсан байна. Нийтийн албан тушаалтны хууль ёсны хөрөнгөөс давсан, өмчлөл эзэмшилд нь байгаа, хууль ёсны эх үүсвэр тодорхойгүй хөрөнгө түүнээс олсон орлогыг нөхөн төлүүлэх ажиллагааны талаар одоогийнхтой ижил ямар нэгэн бие даасан хуулийн зохицуулалтгүй байгаа нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 31 дүгээр зүйлийн хэрэгжилтийг сайжруулах, НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон ОУЭЗХБ-ын Станбулын авлигын эсрэг арга хэмжээний 4 дүгээр шатны зөвлөгөөний дагуу хууль бус хөрөнгийг илрүүлэх, шалгах, хураан авах, нөхөн төлүүлэх ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах ажлын явц байгаа түвшиндээ хэвээр үлдэх магадлалтай. Өөрөөр хэлбэл олон улсын хөндлөнгийн дүгнэлт шинжилгээний дагуу одоогийн Эрүүгийн хууль дахь хууль бус хөрөнгө орлогыг хураан авах зохицуулалт нь хүчин чадлын хувьд учир дутагдалтай тул тус ажилд ахиц гаргахын тулд бусад салбар эрх зүйн хуулиудаар уг ажиллагааг нарийвчлах, нөхөн төлүүлэх, нийтийн хохирлыг барагдуулах арга хэмжээний нарийн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай.

Хувилбар хоёр-Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 55 дугаар зүйл буюу хөрөнгө буцаах олон улсын хамтын ажиллагаанд манай улсын хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй түвшинд үнэлэгдсэн, 31 дүгээр зүйлийн хэрэгжилт, 57 дугаар зүйлийн хэрэгжилтийг сайжруулж дотоодын

эрх зүйн зохицуулалтыг тохиромжтой хэлбэрээр нарийвчлахыг НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон ОУЭЗХБ-ын Станбулын авлигын эсрэг арга хэмжээний 4 дүгээр шатны зөвлөгөөнд тусгаж байсан. Ингэхдээ дараах асуудлуудын зохицуулалтыг нарийвчлах болон шинээр оруулах шаардлагатай байгаа нь:

1. хууль бус хөрөнгө, түүнээс олсон орлогыг нарийн тодорхойлж, түүний хэлбэрүүд буюу өөр хөрөнгөд хувиргасан, сольсон, арилжаалсан, хууль ёсны хөрөнгөтэй хольсон нөхцөл байдлыг хууль эрх зүйн нэр томьёоны хувьд болон олон улсын эрх зүйн нийтлэг шинжтэй гэрээ конвенц, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн тодорхойлох
2. Хууль бус хөрөнгийг мөрдөн шалгах ажиллагаанд баримтлах зарчмыг анхааран үзэх, хүний эрхтэй холбоотой ойлголтуудыг харгалзах, хөрөнгө орлогоо хуулийн дагуу олсныг нотолж болохыг тусгах
3. Шударга гуравдагч этгээд, шударгаар эзэмшигчийн эрхийг хөрөнгө хураах ажиллагаанд зөрчихгүй байх орчныг бүрдүүлэх
4. Хууль бус хөрөнгийг илрүүлэх, хураах, буцаах ажиллагааны дотоодын эрх зүйн үндсийг олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээтэй уялдаатай байдлаар бүрдүүлэх

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

	Зохицуулалтын хувилбарууд	Хувилбар 1. Нэгдүгээр хувилбарыг Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх тухай шинэ зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх	Хувилбар 2. Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх
Шалгуур үзүүлэлт	Зорилгод хүрэх байдал	Тус хувилбар нь өнөөгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхгүй. Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, хоорондын уялдаа холбоо алдагдсан өнөөгийн нөхцөл байдал огт өөрчлөгдөхгүй.	Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгосноор авлигын гэмт хэргийн гаралтыг багасгаж тус гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог үр дүнтэй болгох боломжтой болно.
	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Тус хувилбар нь манай улсын өнөөгийн нөхцөл байдалд ямар нэгэн өөрчлөлт бий болгохгүй. Өөрөөр хэлбэл, авлигын гэмт хэргийн гаралт буурахгүй, тус гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө орлогыг хураан авах, хохирол нөхөн төлүүлэлтийн байдал сайжрахгүй буюу өнөөгийн тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэгдэх боломжгүй байна.	Энэхүү хувилбар нь судалгааны өмнөх хэсэгт шалгасны үр дүнд хүний эрх, эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх нь батлагдсан болно. Харин асуудлын онцлогоос шалтгаалж байгаль орчинд ямар нэг нөлөө үзүүлэхээргүй байна.
	Зардал, өгөөжийн харьцаа үр	Тус хувилбарыг хэрэгжүүлснээр нэмэлт зардал гарахгүй хэдий ч өмнө дурдсанаар үр өгөөж муутай болох нь нотлогдож байна.	Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгоход улсын төсвөөс тодорхой хэмжээний зардал гарах нь ойлгомжтой. Харин тийнхүү шинэчлэхдээ өдийг хүртэл Монгол Улсад хөгжүүлсэн авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх байдлаар шийдвэрлэснээр зардал бага гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд илүү оновчтой зохицуулалт болж чадна. Үүний үр дүнд үүсэх үр өгөөж нь манай улсын нийгэм, эдийн засаг, хүний эрхийн нөхцөл байдалд онцгой ач холбогдолтой юм.

	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Тус хувилбарыг сонгосноор Монгол Улсын одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Энэ нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд үр нөлөө багатай бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал хангагдахгүй байх нөхцөлийг бий болгож байна.	Тус хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй.
--	--------------------------------------	--	---

Дээрх судалгаанд үндэслэн тухайн хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дүн

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд зохицуулалтын хувилбар 2 нь хувилбар 1-ээс эерэг үр дүнг үзүүлж байгаа нь харагдаж байна. Мөн зохицуулалтын хувилбар 2-ыг сонгон хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцсэн буюу эдгээрийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй болохыг анхаарах нь зүйтэй.

Гарч болох сөрөг үр дагавар

Гарч болох сөрөг үр дагаврын хувьд зохицуулалтын хувилбар 1 нь хувилбар 2-оос сөрөг үр дагавар ихтэй болох нь зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдлаас харагдаж байна. Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр өнөөгийн тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэгдэх боломжгүй юм.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Сингапур Улс

Сингапур Улс нь Английн эрх зүйн тогтолцооны үндсэн суурьтай улс бөгөөд нийтийн албан тушаалтны хариуцлагын асуудалд хатуу санкцийн арга хэмжээ авдаг хуулийн зохицуулалттайгаараа онцлогтой улс юм. Авлига, хууль бусаар хөрөнгөжих гэмт хэрэг нь хуулийн зохицуулалтын хамрах хүрээний хувьд дан ганц нийтийн бус хувийн салбарыг хамруулсан байдаг. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт 100,000 хүртэлх Сингапур доллароор торгох, нийтийн албан тушаалтныг 7 хүртэлх жилээр хорих, хууль бус хөрөнгө, орлогыг хураах санкцийн арга хэмжээг хуульчилсан. Харин хууль бусаар хөрөнгөжих болон авлигын гэмт хэргээс олсон орлогыг хураахтай холбоотой харилцааг дараах голлох хуулиудаар зохицуулдаг. Эдгээр нь:

- Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль
- Эрүүгийн хууль
- Авлига, мансууруулах бодисын наймаа болон бусад онцгой гэмт хэрэг(түүнтэй холбоотой ашиг орлогыг хураах)-ийн тухай хууль/АМБНББОГХтХ/
- Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай хууль

АМБНББОГХтХ-д авлига, мансууруулах бодисын наймаа, мөнгө угаах гэмт хэрэг болон бусад хүнд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнтэй холбоотойгоор олсон хөрөнгө, ашгийг хураах тухай заасан. Уг хуулийн 6 дугаар зүйл болон 7 дугаар зүйлд заасны дагуу “шүүх прокурорын хүсэлтээр мансууруулах бодисын наймаа эрхэлсэн гэмт хэрэг болон хар тамхитай холбоотой гэмт хэрэг үйлдсэний улмаас гэм буруутай этгээдийн олсон ашиг, орлогыг хураах шийдвэрийг шүүх гаргана”^[47] гэж заажээ. Тус улсын хуулийн зохицуулалтын онцлог нь хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, авлига, албан тушаалын гэмт хэргээс ашиг, орлого олох явдлыг онцгой хүнд гэмт хэрэгт тооцож, олж авсан хууль бус орлого, ашгийг хураан авах зохицуулалтыг тусгайлсан нэг хуульд тусгасан ба Эрүүгийн хууль, Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль, Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай хууль нь нягт уялджээ.

Авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлэх шүүгдэгч нь тус төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн бол прокурорын гаргасан хүсэлтийн дагуу шүүх ял оногдуулахаас өмнө хөрөнгө хураах ажиллагаа явагдах эсэхийг хянан хэлэлцдэг байна. Хэрэв шүүхээс гаргасан хөрөнгө хураах шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд 2-10 жилийн хугацаанд хорих ялаар шийтгэх зохицуулалттай. Түүнчлэн хураах хөрөнгийн хэмжээг хариуцагчийн эзэмшиж байгаа нийт хөрөнгөөс хууль бусаар олж авсан орлогын хэмжээгээр хурааж, түүнээс олсон ашиг орлогыг мөн хамруулан тооцдог байна. Тус хууль нь Сингапурын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр явуулж буй үндэсний хүчин чармайлтынх нь чухалд тооцогдох хууль тогтоомж юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн зах зээл, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх бодлоготой нь нягт уялдаатай байдлаар энэ төрлийн гэмт хэргийн зохицуулалтыг хатуу хэлбэрээр зүйлчилж, бизнесийн орчин, санхүүгийн орчны үнэлгээнд холбогдох олон улсын индекс, шалгуур үзүүлэлтүүдийг хангахад эерэг нөлөө үзүүлдэг онцлогтой. Сингапур Улс нь 2023 оны Авлигын төсөөллийн индексээр 83 оноо авч, 172 улсаас 5 дугаар байрт жагссан.^[48]

АМБНББОГХтХ нь нийтийн албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас олсон ашгийг хураах, хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтмол тайлагнах үүргээ биелүүлэх зохицуулалтыг хийж, олон улсын түвшинд хамтран мөрдөн шалгах, хөрөнгө буцаах ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлдэг. Авлигын хэргийг мөрдөх товчоо, Ерөнхий прокурорын газар нь энэ төрлийн гэмт хэргийг шалгах, мөрдөх эрхтэй байдаг бөгөөд нийтийн албан тушаалтан, санхүүгийн томоохон байгууллагууд, хувийн томоохон ААН болон бусад шаардлагатай гэж үзсэн ААН, албан тушаалтнуудыг хянан шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг. Хамаарах хуулиудад хууль бус хөрөнгийг хураахтай холбоотой голлох хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдгаас нь дурдвал:

АМБНББОГХт хууль:

- 4 дүгээр зүйл. Авлига, албан тушаалын гэмт хэргээс олсон хөрөнгө, орлогын тодорхойлолт,
- 6 дугаар зүйл. Онцгой хүнд гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээс эд мөрийн баримтаар нотлогдсон бол хөрөнгө, орлогыг хураах шийдвэр гаргах шүүхийн бүрэн эрх,
- 13 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор таслан сэргийлэх, хөрөнгө орлогыг түр хураах арга хэмжээний зохицуулалт;

Эрүүгийн байцаан шийтгэх хууль:

- 364 дүгээр зүйл. Гэмт хэрэгт холбогдсон эд хөрөнгийг хураах шийдвэрийг шүүхэд олгох зохицуулалт;

Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай хууль:

Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай хуулиар^[49] онцгой хүнд гэмт хэрэгт тооцох гэмт хэргүүдийн жагсаалтыг гаргасан бөгөөд үүнд АМБНББОГХтХ-тай холбоотой дөрвөн төрлийн гэмт хэргийг онцгой хүндэд тооцохоор зүйлчилсний дотор:

- 51 дүгээр хэсэг. Тус хуульд заасан гэмт хэргээс олсон ашиг орлогыг нуух, хадгалахад дэмжлэг үзүүлэх

- 54 дүгээр зүйл. Тус хуульд заасан гэмт хэргээс ашиг орлого олох, хууль бус хөрөнгийг эзэмших, ашиглах, нуун дарагдуулах

зэргийг шүүхээс тухайн хэргийг шийдвэрлэхдээ хүндрүүлэн үзэхээр тогтоожээ.

Иймд энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд төрийн зүгээс бодлогоор онцгойлон анхаарч хатуу арга хэмжээ авдаг байна. Үүнээс гадна албан тушаалтны хууль бусаар олсон орлого, шүүн таслах ажиллагаа, оногдуулсан ял, хөрөнгийн хэмжээ зэргийг нийтэд ил тодоор мэдээлж байсан олон удаагийн тохиолдол байна.

Тохиолдол 1.

2011 онд Сингапурын Газрын албаны (SLA)-ны технологи, дэд бүтцийн хэлтсийн дэд захирал асан 41 настай Ко Си Ви нь өөрийн байгууллагын албан хаагчтай үгсэн тохиролцож, Хо Йен Тек гэх этгээдээр дамжуулан хуурамч компани байгуулж, өөрийн ажиллаж буй Газрын албанд технологийн засвар үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн нийлүүлэх 282 гэрээ байгуулсан хэргийг илрүүлсэн байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад уг хуйвалдагч гурван этгээд нь хууль бусаар олж авсан мөнгөө өөрсдийн хамаарал бүхий этгээдүүдийн дансаар дамжуулан авч их хэмжээний үнийн дүн бүхий хөрөнгө худалдан авах/спорт ангиллын машин, цаг гэх мэт/, хувьцаа худалдан авах хэлбэрээр зарцуулалт хийсэн нь илэрчээ. Улсын ерөнхий Прокурорын орлогч Аедит Абдулла албан тушаалаа урвуулан ашигласан, мөнгө угаасан хэрэгт буруутгаж хууль бус хөрөнгийг хураах, хорих ял оногдуулах яллах дүгнэлт үйлдсэн байна.^[50] Улмаар шүүхээс тухайн этгээдүүдийг буруутай хэмээн үзэж хууль бусаар олсон

орлогын хэмжээг 12.2 сая доллар хэмээн тогтоож, буруутай албан тушаалтнуудад 10-15 жилийн хорих ял оноож, 7.5 сая долларыг уг этгээдүүдээс хураан авсан байна.

Сингапур улсад хууль бусаар хөрөнгөжсөн албан тушаалтны гэмт хэргийг тухайн хөрөнгийн хэмжээнээс нь хамааруулан ялгаатай шатлалын шүүхээр шийдвэрлэх ажиллагаа явагддаг ба бага, дунд хэмжээний хөрөнгийн хэргийг дүүргийн шүүх, шүүхийн магистратын шатлалд, их хэмжээний хөрөнгө, ашигтай холбоотой хэрэгт дээд шүүх нь шийдвэр гаргаж байсан туршлагауд байна. Үүнийг хуулиар хэмжээг нь тогтоосон гэхээсээ илүү шүүхийн практикаас хамааруулан шийдвэр гаргах шүүхийн шатлалыг тогтоож байжээ. Тухайлбал тохиолдлоор судалсан жишээг гэхэд гэмт хэргийн оролцогчдын албан тушаал, хохирол учруулсан хөрөнгийн хэмжээ, өмнө нь энэ хэлбэрийн гэмт хэрэг үйлдэгдэж байсан эсэхээс хамааруулан дээд шүүхээс шийдвэр гаргасан байна.

Эдгээрээс үзэхэд Сингапур улс нь хууль бусаар олсон орлого(авлига, албан тушаалын гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа)-ыг хураан авах ажиллагаа нь тусгайлсан хуулийн зохицуулалттай болон хэрэгжүүлж буй 32 жилийн туршлагатай улс ба энэ хууль бусаар ашиг, орлого олох гэмт хэрэгт онцгойлсон хатуу зохицуулалттай байна. Сингапурын Эрүүгийн хуулиар хөрөнгө хураах шийдвэр гаргах эрхийг шүүхэд олгож, Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай хуулиар авлига, мансууруулах бодисын наймаанаас хууль бусаар хөрөнгө, орлого олсон үйлдлийг онцгой хүнд гэмт хэрэгт тооцох тухай хуульчилсан байна. Харин хууль бус хөрөнгийг хураах ажиллагаа, мөрдөн шалгах үйл явц/3 байгууллагад эрхийг нь олгосон/, хууль бус хөрөнгөд тооцох үндэслэлийг АМБНББОГХтХ-д нарийвчлан тусгасан байна. Хууль бус хөрөнгийн хэмжээнээс хамааруулан аль шатлалын шүүхээс хөрөнгө хураах шийдвэр гаргах нь тогтоогдох бөгөөд ингэхдээ өмнөх шүүхийн шийдвэрийн практикийг харгалзан тооцдог байна. Мөн хууль бус хөрөнгө орлогыг илрүүлэх, шүүхээр шийдвэрлэх, хууль бусаар олсон хөрөнгө орлогын хэмжээг нийтэд ил тодоор мэдээлдэг онцлогтой байна.

Бүгд Найрамдах Польш Улс

Бүгд Найрамдах Польш Улс нь эх газрын эрх зүйн тогтолцоотой улс ба тус улсад хууль бусаар олсон орлого, тэр дундаа нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон орлогыг хураан авах эрх зүйн орчныг тусгайлан зохицуулсан хууль байхгүй бөгөөд Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар уг харилцааг голчлон зохицуулж байна.

Эрүүгийн хууль/Kodeks Karny/

Эрүүгийн хуулийн 44-45 дугаар зүйлд зааснаар төрийн албан тушаалтан авлига, албан тушаалаа урвуулан ашигласан гэмт хэргийн шинжтэй үйлдлээр олсон эд хөрөнгө, ашиг орлогыг хураах шийдвэр гаргах эрхийг шүүхэд олгохоор хуульчилсан. Улмаар “үндэслэлгүй хөрөнгө”-ийг мөрдөн шалгаж, тухайн этгээдийн хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг нотлогдоогүй тохиолдолд хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзэн авлигатай тэмцэх ажлын хүрээнд тус хөрөнгийг хураахаар дээрх хуульд заажээ. Авлигатай тэмцэх төв газар(Central Anti-Corruption Bureau) нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг мөрдөн шалгах ажиллагааг эрхлэх гол байгууллага бөгөөд цагдаагийн албанд мөн тус эрх байх боловч голцуу авлигын асуудал эрхэлсэн байгууллага тухайн төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах хандлагатай байдаг байна.

Эрүүгийн хуулийн:

45 дугаар зүйл: Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдолд тус хөрөнгийг хураана.

45 дугаар зүйлийн а хэсэгт: Шүүхэд тухайн эд хөрөнгийн хууль ёсны гарал үүслийг нотлоогүй бол тус этгээдийн хууль ёсны орлогоос үлэмж давсан хөрөнгийг хураах эрхийг шүүхэд олгож, өргөтгөсөн хэлбэрээр тус ажиллагааг явуулж болно.^[51]

гэж тус тус заасан байна. Энэ нь 2017 онд хийгдсэн Эрүүгийн хуулийн шинэчлэлийн хүрээнд “өргөтгөсөн хөрөнгө хураах ажиллагаа”-ны тухай ойлголтыг холбогдох хуулиудад нэвтрүүлсэн заалт юм. “Өргөтгөсөн хөрөнгө хураах ажиллагаа” гэдэг нь аливаа этгээд хууль бусаар их хэмжээний хөрөнгө, орлого олсон нь нотлогдох эсвэл сэжиглэгдэж буй тохиолдолд “гуравдагч этгээд”-ийн өмчлөлд буй хууль бус эд хөрөнгө, орлоготой холбогдох хөрөнгийг хураах, битүүмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн явдал юм. Хууль бус хөрөнгө, орлогыг хураах ажиллагааны зохицуулалтыг Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу тусгайлсан журмаар хураах ажиллагааны гүйцэтгэлийг зохицуулдаг байна.

Польшийн Авлигын эсрэг хуулиар төрийн албан хаагчид жил бүр хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргах үүрэгтэй ба үндэслэлгүй буюу хуулийн дагуу олсон нь тогтоогдоогүй хөрөнгө, орлогын их хэмжээний өсөлт нь мөрдөн шалгах ажиллагааг явуулах үндэслэл болж, шалгах ажиллагааны явцад хууль ёсны орлого болох нь нотлогдоогүй тохиолдолд тухайн эд хөрөнгийг хураах шийдвэрийг Эрүүгийн хэргийн шүүхээс гаргадаг байна. Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн тухай иргэний хэргийн нэхэмжлэл/Unjust Enrichment Claims/-ыг гаргаж болох бөгөөд Польшийн Иргэний хуулийн 405 дугаар зүйлд “бусдын эд хөрөнгөөс үндэслэлгүйгээр хөрөнгө, орлого олсон этгээдээс олсон ашиг орлогыг нь буцаан авна...”^[52] хэмээн заасан тул төрд учруулсан хохирлыг барагдуулахаар иргэнд нэхэмжлэл гаргаж болдог хуулийн зохицуулалттай байна. Польш Улс нь Авлигын индексээр 2023 онд 54 оноогоор 172 улсаас 47 дугаар байрт жагссан.^[53] Тус улс нь голлон авлига, албан тушаалын гэмт хэрэг, хөрөнгө шамшигдуулсан тохиолдолд Эрүүгийн шүүхээр хөрөнгө хураан авах шийдвэр гаргах хандлага тус улсад илүүтэй түгээмэл байдаг байна. Эрүүгийн журмаар хөрөнгө хураах ажиллагааны голлох удирдлагыг прокурор удирдан явуулахаар заасан. Хууль бус хөрөнгийг хураахтай холбоотой хуулиудын холбогдох заалтуудын биелэлтийг харуулах тус улсын жишээг авч үзвэл:

Тохиолдол 2.

Марек Хрзановскийн авлигын хэрэг /The Marek Chrzanowski Corruption Scandal/

2018 онд Польшийн Санхүүгийн Хяналтын Газрын (KNF) дарга асан Марек Хрзановски тэрбумтан банкир Лешек Чарнецкигийн банкинд давуу байдал олгосны хариуд хахууль авч байгаа тухай утасны бичлэг олон нийтэд цацагдсан тул Авлигатай тэмцэх төв газраас түүнийг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн байна. Улмаар түүнийг баривчилж, эрх мэдлээ урвуулан ашигласан, авлига авсан хэргээр мөрдөн байцаалт явуулжээ. 2020 онд прокуророос шалгалт дууссан гэж үзэн түүнийг бусдад давуу тал олгосон, авлига авсан хэргээр буруутгаж, нийт 40 сая злот буюу 9.3 сая еврогийн авлига авсан болон хохирол учруулсанд тооцож, энэ хэмжээний хөрөнгийг хураах, 10 жилийн хорих ял оногдуулах яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байна.

Польш Улс нь Иргэний хуулийн зохицуулалтаар төрд хохирол учруулсан этгээдээс иргэний журмаар хохирол барагдуулахаар нэхэмжлэл гарган, тухайн хөрөнгийг хураах зохицуулалттай боловч голцуу хууль бус хөрөнгийг Эрүүгийн журмаар шийдвэрлэж байна.

Ингэхдээ хууль бус хөрөнгийг хураах тусгайлсан хуульгүй ба Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Хөрөнгө хураах ажиллагаатай бусад журмуудад заагдсаны дагуу мөрдөн шалгах, шүүх, шийдвэр гүйцэтгэн хөрөнгө хураах ажиллагааг гүйцэтгэж байна. Авлига, албан тушаалын гэмт хэргийн хувьд Польш Улс нь дунд түвшинд байгаа тул тухайлсан хууль гарган энэ ажиллагааг явуулах шаардлагагүй, одоогийн Эрүүгийн хууль дахь зохицуулалт хангалттай гэж үзэх хандлага дотоодод нь түгээмэл байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгаа буюу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тодорхойлох тандан судалгаа"-ны хүрээнд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэж үр дүнг дараах байдлаар дүгнэв.

Асуудлын гол шалтгаан нөхцөл буюу авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага үндсэн хоёр нөхцөл байдлаас үүдэлтэй байна. Нэгдүгээрт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх болон Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдож байгаа бол, хоёрдугаарт Монгол Улс дахь авлигын гэмт хэргийн гаралт буурахгүй, тус гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн байдал хангалтгүй байгаатай тус тус холбоотой байна.

Дээрхтэй холбоотой судалгааг тайлангийн өмнөх хэсгүүдэд тусгасан ба аргачлалын дагуу эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүдийг тодорхойлсон. Мөн тус хэрэгцээ, шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн тэдгээрээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан болно. Нэгдүгээр хувилбарыг “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх тухай шинэ зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх” гэж, хоёрдугаар хувилбарыг “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх” гэж тус тус тодорхойлсон.

Улмаар тус хоёр хувилбаруудыг зорилгод хүрэх байдал, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр эерэг үр дүн болон сөрөг үр дагаврыг нэг бүрчлэн, нарийвчлан тодорхойллоо. Үүний үр дүнд зорилгод хүрэх байдал, шалгуур үзүүлэлт, хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд зохицуулалтын хувилбар 2 нь хувилбар 1-ээс эерэг үр дүнг үзүүлж байна. Мөн зохицуулалтын хувилбар 2-ыг сонгосноор Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн, хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй байна.

Дүгнэвэл, хувилбар 2 буюу “Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх” нь хэрэгцээ, шаардлагад илүү нийцтэй, асуудлыг шийдвэрлэх арга зам болж чадахаар байна. Ийнхүү эрх зүйн орчинг боловсронгуй болгохдоо Монгол Улсад өдийг хүртэл бий болгосон авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх буюу эрх зүйн зохицуулалт хоорондын уялдаа холбоог сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг сайжруулах (тэр дундаа эрүүгийн эрх зүйн салбарын зохицуулалтын хэрэгжилт, харилцан уялдаатай байдалд анхаарах), авлигатай тэмцэх стратегийг илүү үр дүнтэйгээр тодорхойлж хэрэгжүүлэх байдлаар шийдвэрлэх нь оновчтой юм. Энэ нь ирээдүйд үүсгэж болох үр дагавар нь тодорхойгүй бие даасан, анхдагч хууль батлан гаргахаас илүү үр дүнтэй болохыг үүгээр зөвлөж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж

Монгол хэлээр:

1. Үндсэн хууль, (1992)
2. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, (2001)
3. Эрүүгийн хууль/Шинэчилсэн найруулга/, (2015)
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017)
5. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, (2020)
6. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, (2020)
7. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, (2021)
8. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол

Гадаад хэлээр:

1. Singapore, Corruption, Drug Trafficking and Other Serious Crimes (Confiscation of Benefits) Act 1992
2. Singapore, Prevention of Corruption Act, 1960
3. Singapore, Organised Crime Act, 2015
4. Singapore, Penal Code, 1871
5. Republic of Poland, The Criminal Code, Kodeks Karny, 1997.
6. Republic of Poland, Civil Code, Kodeks cywilny, 1964.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. Авлигатай тэмцэх газар, Түүхэн замнал <https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhem-zarchim>
2. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номны тоон мэдээнээс, /2020, 2021, 2022 он/
3. Авлигатай тэмцэх газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 28 дахь тал.
4. Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он, 81 дэх тал.
5. Д.Бадам “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй(Тайлбар толь)” 2018 он, 6 дахь тал.
6. Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, “Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, УБ., 2020 он, 419-420 дахь тал.
7. Э.Өнөболд, Э.Цэрэнханд, “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг оногдуулсан хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт өгүүлэл, <https://legalddata.mn/buteel/pdf?id=1755>
8. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг буцаан авах ажиллагаа /Гарын авлага/, УЕПГ, АТГ, 2020 он.
9. Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2009), 72 дахь тал.
10. Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар, (УБ, 2022), 194 дэх тал.
11. Н.Чинбат, Иргэний эрх зүйн лекцийн товчоон, (УБ, 2014 он), 180 дахь тал.
12. Н.Баярмаа, Монгол Улс дахь төрийн нийтийн өмч: Газар ба үл хөдлөх эд хөрөнгө газрын хэвлийн баялаг ба хувьцаа, (УБ, 2021 он), 39 дэх тал.
13. Ж.Оюунтунгалаг, “Бусдын зардлаар хөрөнгөжсөнтэй холбоотой үүрэг”, Хууль дээдлэх ёс сэтгүүл No4 (2017), 6 дахь тал.

14. ХЗҮХ, Иргэний хуулийн “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ – Судалгааны тайлан, УБ 2024 он, 9 дэх тал.
15. Б.Буянхишиг, “Иргэний эрх зүйн удиртгал” УБ 2014 он, 118-119 дэх тал.
16. НҮБ-Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II, V бүлгийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлан, (Вена, 2023)
17. ЭЗХАХБ, Зүүн Европ, Төв Ази дахь авлигатай тэмцэх ажиллагаа, Станбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шат тайлан, Орч. Ц.Шинэбаяр, Х.Билгүүн болон бусад, (УБ, 2019), 11 дахь тал.
18. ФАТФ, ФАТФ-ын зөвлөмж-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, Орч. Санхүүгийн мэдээллийн алба, (Парис, 2019), ЭЗХАХБ, 12 дахь тал.

Гадаад хэлээр:

1. Geneva Centre for the Democratic Control of Armed Forces (DCAF), “International Standards Compilation of Good Practices for Intelligence Agencies and their Oversight”
2. Martin Scheinin “Report of the Special Rapporteur on the promotion and protection of human rights and fundamental freedoms while countering terrorism”, Human Rights Council Fourteenth session Agenda item 3
3. Mr Iain Cameron (Member, Sweden), “REPORT ON THE DEMOCRATIC OVERSIGHT OF SIGNALS INTELLIGENCE AGENCIES” Adopted by the Venice Commission at its 102nd Plenary Session (Venice, 20-21 March 2015)
4. European parliament, “PARLIAMENTARY OVERSIGHT OF SECURITY AND INTELLIGENCE AGENCIES IN THE EUROPEAN UNION” Study
5. Norbet Putter, “The Federal Republic’s security services from the Cold War o the “new security architecture””, Statewatch Analysis
6. European parliament, “PARLIAMENTARY OVERSIGHT OF SECURITY AND INTELLIGENCE AGENCIES IN THE EUROPEAN UNION” Study

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn>
2. Монгол Улсын тагнуулын ерөнхий газрын цахим хуудас, <https://www.gia.gov.mn/>

Гадаад хэлээр:

1. Transparency International, Corruption Perceptions Index, 2024, https://www.transparency.org/en/cpi/2023?gad_source=1&qclid=CjwKCAiAjeW6BhBAEiwAdKltMp3ldt6Uo9qvi6u3z8ckLOUwIxcPmDwp6zVw69opJQI_sYsl_fmAAhoCw8EQAvD_BwE
2. Instrumente der politischen Kontrolle, <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/politische-kontrolle>
3. Politische und rechtliche Kontrolle, <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/rechtliche-kontrolle>
4. Finanzielle Kontrolle im Überblick, <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/finanzielle-kontrolle>
5. Rechnungshof, <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/rechnungshof>
6. Volksanwaltschaft: Unabhängige Kontrolleinrichtung, <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/volksanwaltschaft>

7. Ein einzigartiges Gericht, <https://www.parlament.gv.at/verstehen/politisches-system/kontrolle/verfassungsgerichtshof>
8. National intelligence authorities and surveillance in the EU: Fundamental rights safeguards and remedies AUSTRIA Version of 22 September 2014, https://fra.europa.eu/sites/default/files/fra_uploads/austria-study-data-surveillance-at.pdf

Шүүхийн шийдвэр:

1. Public Prosecutor v Koh Seah Wee and another[2011] SGHC 240, 2011. Supreme Court Judgement of Singapore website: https://www.elitigation.sg/gd/s/2011_SGHC_240

ХАВСРАЛТ

- [1] Авлигатай тэмцэх газар, Түүхэн замнал <https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhenzarchim>
- [2] Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номны тоон мэдээнээс, /2020, 2021, 2022 он/
- [3] Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан номны тоон мэдээнээс, /2020, 2021, 2022 он/
- [4] Мөн тэнд.
- [5] Авлигатай тэмцэх газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан, 28 дахь тал.
- [6] Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он, 81 дэх тал.
- [7] Д.Бадам “Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй(Тайлбар толь)” 2018 он, 6 дахь тал.
- [8] Г.Гантөмөр, Б.Энхболд, С.Гантулга, “Эрүүгийн эрх зүй Ерөнхий анги”, УБ., 2020 он, 419-420 дахь тал.
- [9] Э.Өнөболд, Э.Цэрэнханд, “Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг оногдуулсан хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт өгүүлэл, <https://legaldata.mn/buteel/pdf?id=1755>
- [10] Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг буцаан авах ажиллагаа /Гарын авлага/, УЕПГ, АТГ, 2020 он.
- [11] Ханнс-Зайделийн сан, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, (УБ, 2009), 72 дахь тал.
- [12] Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 194 дэх тал.
- [13] Ханнс-Зайделийн сан, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, (УБ, 2009), 72 дахь тал.
- [14] Мөн тэнд.
- [15] Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 195 дахь тал.
- [16] Мөн тэнд.
- [17] Ханнс-Зайделийн сан, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, (УБ, 2009), 72 дахь тал.
- [18] Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 288 дахь тал.
- [19] Ханнс-Зайделийн сан, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, (УБ, 2009), 72 дахь тал.
- [20] Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хууль шинжлэх ухааны тайлбар*, (УБ, 2022), 66 дахь тал.
- [21] Н.Чинбат, *Иргэний эрх зүйн лекцийн товчоон*, (УБ, 2014 он), 180 дахь тал.
- [22] Н.Баярмаа, Монгол Улс дахь төрийн нийтийн өмч: Газар ба үл хөдлөх эд хөрөнгө газрын хэвлийн баялаг ба хувьцаа, (УБ, 2021 он), 39 дэх тал.
- [23] Ж.Оюунтунгалаг, “Бусдын зардлаар хөрөнгөжсөнтэй холбоотой үүрэг”, Хууль дээдлэх ёс сэтгүүл No4 (2017), 6 дахь тал.
- [24] ХЗҮХ, Иргэний хуулийн “Үндэслэлгүйгээр хөрөнгөжих” зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ – Судалгааны тайлан, УБ 2024 он, 9 дэх тал.
- [25] Б.Буянхишиг, “Иргэний эрх зүйн удиртгал” УБ 2014 он, 118-119 дэх тал.
- [26] Эрүүгийн хууль, 22 дугаар зүйлийн 1 дэх заалт.
- [27] ХЗҮХ, “Иргэний хуулийн үндэслэлгүйгээр хөрөнгөжих зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ” судалгааны тайлан УБ 2024 он, 17 дахь тал.
- [28] Мөн тэнд

- [29] Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, (УБ, 2017), 394-398 дахь тал.
- [30] Захиргааны ерөнхий хууль, 103 дугаар зүйлийн 103.1 дэх заалт.
- [31] Захиргааны ерөнхий хууль, 105 дугаар зүйлийн 105.2.1 дэх заалт.
- [32] Захиргааны ерөнхий хууль, 105 дугаар зүйлийн 105.2.2 дахь заалт.
- [33] Захиргааны ерөнхий хууль, 105 дугаар зүйлийн 105.2.3 дахь заалт.
- [34] Захиргааны ерөнхий хууль, 105 дугаар зүйлийн 105.2.4 дэх заалт.
- [35] Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, (УБ, 2017), 420 дахь тал.
- [36] Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, Сургагч багш нарт зориулсан гарын авлага, (УБ, 2017), 16 дахь тал.
- [37] Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 31 дүгээр зүйл.
- [38] Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 2 дугаар зүйл.
- [39] Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 2 дугаар зүйл.
- [40] НҮБ-Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II, V бүлгийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлан, (Вена, 2023), 15 дахь тал.
- [41] Мөн тэнд
- [42] ЭЗХАХБ, Зүүн Европ, Төв Ази дахь авлигтай тэмцэх ажиллагаа, Станбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шат тайлан, Орч. Ц.Шинэбаяр, Х.Билгүүн болон бусад, (УБ, 2019), 11 дахь тал.
- [43] ЭЗХАХБ, Зүүн Европ, Төв Ази дахь авлигтай тэмцэх ажиллагаа, Станбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шат тайлан, Орч. Ц.Шинэбаяр, Х.Билгүүн болон бусад, (УБ, 2019), 19 дахь тал.
- [44] ЭЗХАХБ, Зүүн Европ, Төв Ази дахь авлигтай тэмцэх ажиллагаа, Станбулын Авлигын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний дөрөвдүгээр үе шат тайлан, Орч. Ц.Шинэбаяр, Х.Билгүүн болон бусад, (УБ, 2019), 20 дахь тал.
- [45] НҮБ-Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II, V бүлгийн хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлан, (УБ, 2023), 15 дахь тал.
- [46] ФАТФ, ФАТФ-ын зөвлөмж-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, Орч. Санхүүгийн мэдээллийн алба, (Парис, 2019), ЭЗХАХБ, 12 дахь тал.
- [47] Сингапур Улсын Авлига, мансууруулах бодисын наймаа болон бусад онцгой гэмт хэрэг(түүнтэй холбоотой ашиг орлогыг хураах)-ийн тухай хууль (Corruption, Drug Trafficking and Other Serious Crimes(Confiscation of Benefits) Act of Singapore, 1992).
- [48] Transparency International, Corruption Perceptions Index, 2024, https://www.transparency.org/en/cpi/2023?gad_source=1&gclid=CjwKCAiAjeW6BhBAEiwAdKltMp3l dt6Uo9qvi6u3z8ckLOUwlxcPmDwp6zVw69opJQI sYsl fmAAhoCw8EQAvD BwE, Сүүлд үзсэн: (2024.12.12).
- [49] Сингапур Улсын Зохион байгуулалттай гэмт хэргийн тухай хууль, (Organized Crime Act of Singapore, 2015).
- [50] Public Prosecutor v Koh Seah Wee and another[2011] SGHC 240, 2011. Supreme Court Judgement of Singapore website: <https://www.elitigation.sg/gd/s/2011 SGHC 240> Сүүлд үзсэн: (2024.12.15).
- [51] Бүгд Найрамдах Польш Улсын Эрүүгийн хууль, (Kodeks Karny, 1997).

[52] Бүгд Найрамдах Польш Улсын Иргэний хууль, (Kodeks cywilny, 1964).

[53] Transparency International, Corruption Perceptions Index, 2024,

https://www.transparency.org/en/cpi/2023?gad_source=1&gclid=CjwKCAiAjeW6BhBAEiwAdKltMp3l dt6Uo9qvi6u3z8ckLOUwlxcPmDwp6zVw69opJQI_sYsl_fmAAhoCw8EQAvD_BwE, Сүүлд үзсэн:

(2024.12.12).